

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: СНАГ-2024/01/-НА-СТА-ЗГСНТ

2024 он

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг

Аудитын менежер:
Д.Энхдалай
Б.Долгорсүрэн
Б.Лхагвацэнд

Ахлах аудитор:
П.Амарсанаа
А.Даваадорж
Б.Долгоржав
О.Баярмаа

Аудитор:
М.Ганбаатар
Ж.Бүжигханд
Ж.Нямцэцэг
Ж.Мөнхтуул
Г.Оюунгөгөлдөр
Э.Булганчимэг
П.Цогзолмаа
Я.Марал-Эрдэнэ
С.Отгонхорлоо
М.Пагамдулам

2024 оны 6 дугаар сар

Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ
ҮҮ:
www.audit.mn

Аудитын тайлангай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаар утсаар харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-6,
Улаанбаатар-46
Монгол Улс

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	6
2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6
2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	7
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	8
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9
3. АУДИТЫН ТАЙЛАН	10
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	10
3.1.1 Аудит хийсэн үндэслэл	10
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ	10
3.1.3 Аудитын арга зүй	10
3.1.4 Материаллаг байдлын түвшин	10
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	10
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж	11
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	11
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	11
3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	11
3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	11
3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	12
3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	12
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	12
Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	13
Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	14
Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	14
Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	15
4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	16
4.3 АВЛАГА	16
Төв төрийн сангийн авлага	17
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	17
Төсөвт байгууллагын авлага	18
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага	19
Нийгмийн даатгалын сангийн авлага	20
Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага	20
4.4 УРЬДЧИЛГАА	21
4.5 БАРАА МАТЕРИАЛ	21
4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	22
4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	23
4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23
4.9 ӨР ТӨЛБӨР	24
Төв төрийн сангийн өр төлбөр	25
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр	26
Төсөвт байгууллагын өр төлбөр	27
Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр	27
Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр	27
4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	28
4.11 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	28
Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	29
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	29
Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит	29
Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит	31
Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит	32
Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит	33
4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ ААРИЙЭВСЭН БАЙГУУЛЛАГА АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА	34

4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	34
4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	34
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	35
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ	35
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	36



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тосйруу 3, Засгийн газрын IV байр
Утас 26-04 37, Факс 51 26 42-30
E mail: info@audit.gov.mn

2024 06 07 № 1466

танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчил, түүний санхүүгийн тайлан, тодруулгад үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1,111.1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
2. Гадаад зээлээр санхүүжүүлсэн 2018-2022 онд хэрэгжиж дууссан "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл"-ийн нийт 176.7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, авлагаар бүртгээгүй;
3. Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний дагуу 2012 онд олгосон Бэрэн групп ХХК 173.6 тэрбум төгрөг, Цагаан хуаран консалтинг ХХК 65.6 тэрбум төгрөг, нийт 239.2 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний дагуу маргааныг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй;
4. Гадаад зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 10 төсөл хөтөлбөрийн бусад эргэлтийн хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй нийт 534.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлж, төслийн хаалтыг хийж, санхүүгийн тайлан бэлтгээгүй;

АУДИТЫН САНАЛ
ДҮГНЭЛТ

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл


Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

Z:\Yawsan_Bichig\2024\0607 SNAG-3 Docx



5. Монголбанк дахь Ирээдүйн өв сангийн дансанд нийт 1,300.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг байршуулсан боловч хүүгийн орлого төвлөрүүлэх гэрээ байгуулаагүй нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын тогтоолоор Монголросцветмет ТӨҮГ, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Эрдэнэс ҮТП ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Цемент шохой ТӨХК -ийг Эрдэнэс Монгол нэгдлийн бүрэлдэхүүнд нэгтгэн, компаниудын дүрэм батлах, шинэчлэх арга хэмжээг авсан байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагын Эрдэнэс ҮТП ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилга угсралтын ажлыг эхний байдлаар 2022 онд ашиглалтад оруулсан бөгөөд бусад эрчим хүч хангамж, төмөр замын дээд, доод бүтэц, гүүр хоолой, хиймэл байгууламж, дохиолол холбоо, зөрлөгүүдийн зам, барилга байгууламжийг тайлант онд улсын комиссын дүгнэлтээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК олон улсын зах зээлд Засгийн газрын баталгаатай гаргасан 30 тэрбум иений "Самурай" үнэт цаасны 720.0 тэрбум төгрөг, "Евро" үнэт цаасны 1,548.0 тэрбум төгрөг, нийт 2,268.0 тэрбум төгрөгийн үлдэгдэл төлбөрийг бүрэн төлжээ.

Тайлант онд "Сенчири II", "Сенчири III" үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалан 2,966.6 тэрбум төгрөгийн дахин санхүүжилт хийж, улсын төсвөөс 315.7 тэрбум төгрөгийг гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт (үүнээс "Гэрэгэ" үнэт цаасны төлбөрт 1,797.6 тэрбум төгрөг, "Хуралдай" үнэт цаасны төлбөрт 1,484.7 тэрбум төгрөг) төлж, гадаад өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасган зохицуулалт хийсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороог шинээр байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланг Засгийн газрын тайланд нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 269 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгаж, тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-д шилжүүлсэн.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр 1991-2023 онд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийт 8.7 тэрбум ам.долларын зээл авч, нийгэм, дэд бүтцийн салбаруудыг санхүүжүүлсэн нь зээлийн өртөг болон импортод чиглэсэн төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлсэн, гадаад валютын нөөцөд дарамт учруулах эрсдэлтэй, гадаад зээлийн санхүүжилтээс хараат байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


Д.ЗАГДЖАВ

АУДИТЫН САНАЛ
ДҮГНЭЛТ

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

Z:\Yawsan_Bichig\2024\0607 SNAG-3 Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалах сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БЗС	Боловсролын зээлийн сан
ГХС	Гадаад харилцааны сайд
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЕП	Монгол Улсын Ерөнхий прокурор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
МУДШ	Монгол Улсын Дээд шүүх
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНТЭЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУ	Олон улс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
УУХУС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан
ХААК	Хөдөө аж ахуйн корпораци
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХУС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЦХХХС	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,085,928,182.2	39,419,277,113.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,636,670,569.7	12,090,945,132.6
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	451,498,301.8	418,881,028.8
33	АВЛАГА	6,333,845,839.8	6,445,231,920.4
34	УРЬДЧИЛГАА	3,614,482,618.1	5,137,620,748.6
35	БАРАА МАТЕРИАЛ	3,274,598,719.0	3,651,951,120.1
36	НӨӨЦИЙН БАРАА	210,633,101.5	210,051,565.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	8,564,199,032.3	11,464,595,597.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	63,893,604,846.1	67,291,238,825.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11,558,499,535.0	11,769,862,213.5
37100	Урт хугацаат хадгаламж	56,896,723.5	60,011,802.6
37200	Үнэт цаас	3,506,320,839.9	3,270,019,664.8
37300	Урт хугацаат зээл	7,995,281,971.6	8,439,830,746.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	52,335,105,311.2	55,521,376,611.9
39100	Газар	59,832,063.6	45,966,490.4
39200	Биет хөрөнгө	27,443,237,064.3	29,965,023,636.4
39300	Биет бус хөрөнгө	18,747,039,260.4	19,086,188,106.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,084,996,922.8	6,424,198,378.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II	92,979,533,028.4	106,710,515,938.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	53,194,708,976.1	55,194,185,569.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,631,708,126.4	12,747,684,009.8
41100	Богино хугацаат үнэт цаас	15,575,304.0	512,800,167.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	2,373,969,929.7	3,199,246,995.7
41300	Өглөг	3,872,434,970.3	5,790,559,799.8
41400	Урьдчилж орсон орлого	2,369,727,922.3	3,245,077,047.3
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,563,000,849.7	42,446,501,560.1
42100	Урт хугацаат үнэт цаас	16,855,319,698.2	13,595,979,135.8
42200	Урт хугацаат зээл	27,707,681,151.5	28,850,522,424.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	39,784,824,052.3	51,516,330,368.6
51	Засгийн газрын хувь оролцоо	39,769,380,855.4	51,500,867,171.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,744,011,204.5	8,029,230,876.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	6,913,385,684.2	7,032,475,637.8
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	490.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,243,630,593.6	11,255,546,353.9
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	18,816,486.3	18,816,486.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	8,299,306,303.6	9,608,439,840.2
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,077,924,986.6)	7,962,257,539.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,463,186,240.8	7,444,269,487.7
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	164,949,349.1	149,867,039.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(36,579.0)
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	15,463,196.9	15,463,196.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	92,979,533,028.4	106,710,515,938.5

Аудитын санал
дүгнэлт

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
илэрүлгэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,213,315,061.5	42,806,640,395.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,959,521,176.6	22,517,720,993.2
110	Орлогын албан татвар	3,847,312,563.7	5,928,733,767.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,363,481,979.4	1,885,081,947.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(51,137,076.5)	(64,524,799.5)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	6,531.0	8,415.4
1103	ААН-ын орлогын албан татвар	2,534,961,129.8	4,108,168,203.4
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,215,247,676.9	4,184,392,112.1
113	Хөрөнгийн албан татвар	237,578,396.6	394,899,780.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,946,188,205.2	4,791,429,999.5
115	Онцгой албан татвар	847,805,078.6	790,106,602.8
116	Тусгай зориулалтын орлого	19,353,935.1	21,623,528.1
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,255,537,126.9	1,470,679,247.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,590,498,193.7	4,935,855,955.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,771,819,684.2	20,107,466,980.4
120	Нийтлэг татварын бус орлого	13,336,384,865.9	19,712,069,037.2
121	Хөрөнгийн орлого	6,103,401.4	9,874,524.2
122	Тусламжийн орлого	429,331,417.0	378,730,223.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
124	Зээлийн орлого	-	6,793,195.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	481,974,200.7	181,452,422.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,393,820,639.0	28,870,897,862.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,368,931,440.6	28,828,467,769.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,331,803,890.2	19,267,915,399.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,721,053,546.4	4,981,120,212.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	404,783,350.4	533,863,660.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	434,314,734.6	511,367,081.6
2104	Хангамж, бараа материалын зардал	579,255,078.5	756,430,479.9
2105	Нормативт зардал	668,933,933.2	709,817,910.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	223,866,100.4	175,171,069.6
2107	Томилолт, зочны зардал	81,925,186.0	114,799,766.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,126,387,287.2	8,450,228,438.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,091,304,673.5	3,035,116,780.6
211	ХҮҮ	1,169,413,102.9	1,629,919,018.9
212	ТАТААС	1,046,492,835.2	657,447,140.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,821,221,612.3	7,273,188,210.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,889,198.4	42,430,092.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,819,494,422.5	13,935,742,533.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,577,659,743.7	5,563,099,951.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,280,746,933.5	8,339,672,193.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,116,407,232.6	11,159,170,291.0

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,969,604,286.0	-	37,969,604,286.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	521,543,616.0	-	521,543,616.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,491,147,902.0	-	38,491,147,902.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(72,189,147.5)	-	(72,189,147.5)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(1,047,023,268.8)	-	(1,047,023,268.8)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	80,189,961.2	-	80,189,961.2
Өмчид гарсан өөрчлөлт	713,782,239.8	-	713,782,239.8
Зарласан ногдол ашиг	(497,490,867.0)	-	(497,490,867.0)
Тайлант үеийн үр дүн	2,116,407,232.6	-	2,116,407,232.6
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,784,824,052.3	-	39,784,824,052.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(636,723,467.2)	-	(636,723,467.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,148,100,585.1	-	39,148,100,585.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,233,304.0	-	2,233,304.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	302,018,042.4	-	302,018,042.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(972,801.4)	-	(972,801.4)
Өмчид гарсан өөрчлөлт	1,374,503,463.6	-	1,374,503,463.6
Зарласан ногдол ашиг	(477,356,071.3)	-	(477,356,071.3)
Тайлант үеийн үр дүн	11,167,803,846.1	-	11,167,803,846.1
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,516,330,368.6	-	51,516,330,368.6

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бүсэд асуудал

Дүгнэлт, зөвлөмж

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	36,766,643,089.8	54,752,207,804.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,471,403,390.9	22,813,069,711.7
110	Орлогын албан татвар	3,821,510,763.9	5,932,238,693.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,362,751,435.1	1,888,562,750.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(51,137,076.5)	(64,500,676.2)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	6,531.0	8,415.4
1103	ААН-ын орлогын албан татвар	2,509,889,874.3	4,108,168,203.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,163,128,287.4	4,149,150,964.1
113	Хөрөнгийн албан татвар	237,587,069.6	394,816,367.3
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,848,299,871.0	4,779,728,129.4
115	Онцгой албан татвар	807,197,252.5	790,106,602.8
116	Тусгай зориулалтын орлого	19,353,935.1	21,623,528.1
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,292,189,505.6	1,465,340,213.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,282,136,705.9	5,280,065,212.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,988,270,544.1	4,959,653,364.0
1181	Газрын төлбөр	188,103,764.7	194,609,052.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	93,995,917.8	110,341,807.3
1183	Бусад татвар	11,766,479.3	15,460,988.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,466,211,561.0	31,276,817,245.8
120	Нийтлэг татварын бус орлого	19,377,886,004.7	31,181,047,346.5
121	Хөрөнгийн орлого	6,177,018.0	9,874,524.2
122	Тусламжийн орлого	81,313,403.0	85,093,581.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	835,135.3	801,794.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	829,028,137.8	662,320,847.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,374,191,498.4	39,949,103,843.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,374,191,498.4	39,949,103,843.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,938,827,345.8	30,054,589,658.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,906,447,896.1	6,454,858,139.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	757,944,987.2	964,978,245.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	838,019,258.8	1,024,231,504.4
2104	Хангамж, бараа материалын зардал	3,940,774,081.1	5,805,252,971.2
2105	Нормативт зардал	671,430,125.8	564,445,092.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	177,941,271.7	203,123,325.6
2107	Томилголт, зочны зардал	82,046,445.6	115,653,437.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,518,087,036.2	13,769,964,825.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,046,136,243.3	1,152,082,116.3
211	ХҮҮ	1,118,687,808.1	1,670,643,632.8
212	ТАТААС	543,947,221.1	470,663,109.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,772,729,123.4	7,753,207,443.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,392,451,591.3	14,803,103,961.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	23,737,304,161.1	10,962,821,723.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,718,849,498.0	17,148,319,196.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,718,849,498.0	17,148,319,196.2
2200	Дотоод эх үүсвэрээр	29,717,052,090.0	17,145,069,525.2
2260	Гадаад эх үүсвэрээр	1,797,408.0	3,249,671.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,981,545,336.9)	(6,185,497,473.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	205,126,953.2	(3,003,451,819.7)
14	Бусад эх үүсвэр	4,388,269,329.8	5,471,176,806.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	181,119,833.7	344,088,900.9
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	1,430,974,868.6	3,680,380,794.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,571,047,674.4	4,450,158,930.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,616,033,207.6	5,614,154,668.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,020,637,362.1	6,636,670,569.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,636,670,569.7	12,090,945,132.6

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 34,674.5 тэрбум төгрөгийн 1.0 хувь буюу 346.7 тэрбум төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 13,135.7 тэрбум төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 38,786.3 тэрбум төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 50,136.2 тэрбум төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Аудитын санал
дүгнэлт

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
ирүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв төрийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, улсын болон орон нутгийн 62 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 5442 төсөвт байгууллага, үүнээс 2496 гүйцэтгэл, үр дүнгээр санхүүждэг байгууллага, 619 төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, 370 төрийн сан, 295 төсөл, сан, нийт 6726 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 106,710.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 14.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	29,085,928.2	39,419,277.1	10,333,348.9	36.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	63,893,604.8	67,291,238.8	3,397,634.0	63.1
Нийт хөрөнгийн дүн	92,979,533.0	106,710,515.9	13,730,982.9	100.0
Нийт өр төлбөр	53,194,709.0	55,194,185.6	1,999,476.6	51.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	39,784,824.0	51,516,330.3	11,731,506.3	48.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	92,979,533.0	106,710,515.9	13,730,982.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 13,730.9 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК 3,176.9 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 1,325.8 тэрбум төгрөг, Ирээдүй өв сан 1,300.0 тэрбум төгрөг, Төрийн банк ХК 1,203.6 тэрбум төгрөг, Эрдэнэс алт ресурс ХХК 1,103.0 тэрбум төгрөг, Монголын хөрөнгийн бирж ХК-ийн хөрөнгө 901.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 11,159.2 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 5,066.0 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 3,060.6 тэрбум төгрөг, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 2,046.4 тэрбум төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн 986.2 тэрбум төгрөгийн эерэг /орлого нь зардлаасаа их/ үзүүлэлттэй гарсан байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2023 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 11,731.5 тэрбум төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 9,042.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2023 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 54,752.2 тэрбум төгрөг, зарлага 39,949.1 тэрбум төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 14,803.1 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлсэн байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12,090.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 5,454.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	57,015.6	65,932.9	8,917.3	0.5
Банканд байгаа бэлэн мөнгө	6,393,229.9	11,644,830.4	5,251,600.5	96.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	100,813.4	175,036.0	74,222.6	1.4
Хадгаламж	85,611.7	205,145.8	119,534.1	1.7
Дүн	6,636,670.6	12,090,945.1	5,454,274.5	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,742,673.1	6,386,879.0	2,644,205.9	52.8
Төрийн сан	1,309,179.8	2,034,989.4	725,809.6	16.9
Төсөвт байгууллага	473,856.0	753,600.2	279,744.2	6.2
Төсөл/ сан	1,110,961.7	2,915,476.5	1,804,514.8	24.1
Дүн	6,636,670.6	12,090,945.1	5,454,274.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,454.2 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 2,644.2 тэрбум төгрөг, төрийн сан 725.8 тэрбум төгрөг, төсөвт байгууллага 279.7 тэрбум төгрөг, төсөл сангийн мөнгөн хөрөнгө 1,804.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Банканд байгаа мөнгөний хөрөнгийн 11,644.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлд гадаад валютын 4,095.3 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна. Үүнээс 2,336.4 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 1,606.1 тэрбум төгрөг нь төрийн сангийн, 79.1 тэрбум төгрөг нь төсөл сангийн, 73.7 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын гадаад валютын үлдэгдэл байна.

Арилжааны банканд байгаа мөнгөний нийт 6,055.8 тэрбум төгрөгийн 75.0 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 22.8 хувийг төсөл сангийн, 1.7 хувийг төсөвт байгууллагын, 0.5 хувийг төрийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 205.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 119.5 тэрбум төгрөгөөр буюу 139 хувиар өссөн байна.

Хүснэгт №3. Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө /сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Зээлийн батлан даалтын сан	22,673.6	131,076.3	108,402.7	63.9
Монгол Улсын Их сургууль	23,218.0	19,023.7	(4,194.3)	9.3
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	10,230.2	5,549.9	(4,680.3)	2.7
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	7,042.9	10,599.0	3,556.1	5.2
Монгол Улсын Боловсролын Их Сургууль	9,290.8	17,553.1	8,262.3	8.6
Монголын цахилгаан холбоо ХК	1,500.0	1,500.0	-	0.7
Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	3,391.8	7,781.6	4,389.8	3.8
Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжил нэгж	1,363.3	1,472.4	109.1	0.7
Биокомбинат ТӨХХК	310.0	-	(310.0)	-
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ	-	2,000.0	2,000.0	0.0

01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ 12

Аудитын санал дүгнэлт
Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан
Үндсэн мэдээлэл
Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн
Онцлох, гол, бусад асуудал
Аудитын илрүүлэлт
Дүгнэлт, зөвлөмж

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Гүний ус ОНӨААТҮГ	37.7	56.7	19.0	-
Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа ТӨААТҮГ	-	1,202.2	1,202.2	0.6
Удирдлагын академи ТӨҮГ	6,553.4	7,330.8	777.4	3.5
Дүн	85,611.7	205,145.7	119,534.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд Зээлийн батлан даалтын сангийн хадгаламж 108.4 тэрбум төгрөгөөр, Монгол Улсын Боловсролын их сургуулийн хадгаламж 8.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ 2.0 тэрбум төгрөгийн, Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа ТӨААТҮГ 1.2 тэрбум төгрөгийн хадгаламжийг шинээр нээсэн зэргээс шалтгаалан 119.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,773.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 601.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Төв төрийн сангийн мөнөөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	1,104,248.5	1,664,413.3	560,164.8	93.9
Төгрөг	71,793.2	79,697.7	7,904.5	4.5
Төрийн сан	55,458.2	63,316.8	7,858.6	3.6
Монголбанк	8,857.0	8,857.0	-	0.5
Арилжааны банк	7,478.0	7,523.9	45.9	0.4
Монголбанк /гадаад валют/	1,032,455.3	1,584,715.6	552,260.3	89.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	67,610.6	108,926.3	41,315.7	6.1
Дүн	1,171,859.1	1,773,339.6	601,480.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 4.5 хувийг төгрөгийн харилцах, 89.4 хувийг гадаад валютын харилцах, 6.1 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгөд үйл ажиллагааны орлогоос 16,206.1 тэрбум төгрөг, зээлийн эргэн төлөлт, бусад эх үүсвэрээс 3,141.6 тэрбум төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 105.9 тэрбум төгрөг, нийт 19,453.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, урсгал зардалд 12,064.6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 2,857.5 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх зээл 138.7 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 3,666.5 тэрбум төгрөг, ханшийн зөрүүнд 124.8 тэрбум төгрөг, нийт 18,852.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тайланд 3.0 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй байна. /ШЕЗ-ийн төрийн санд байрших барьцаа хөрөнгийн 13 дансны үлдэгдэл 3.0 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.03 тэрбум төгрөг/;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын харьяаны төрийн өмчийн 50 хувиас доош хувийн оролцоотой байгууллагын 44.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгүй;
- Төв төрийн сангийн 4,800.8 тэрбум төгрөгийн зарлагын эх үүсвэрийн дутагдлыг бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлэн санхүүгийн тайланд богино хугацаат зээлийн өглөгөөр тайлагнаж, Засгийн газрын нэгтгэсэн тайланд 36 байгууллага, сан, ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж цэвэрлэх бичилт хийсэн байна.
- Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж байгаа 200.7 тэрбум төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршиж байгаа 45.3 тэрбум төгрөг, нийт 256.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн;
- Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоол, 2020 оны 253 дугаар тогтоол, 2021 оны 397 дугаар тогтоол, 2022 оны 495 дугаар тогтоол, 2023 оны 456 дугаар тогтоолоор нийт 1,096.1 тэрбум төгрөгийн тайлант онд хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 -д заасныг зөрчиж, ТЕЗ нарын барьцаа хөрөнгийн дансанд жил бүр төвлөрүүлсэн. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөнөөс 327.9 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан үлдэгдлийг хянаж, санхүүжүүлэхээр байна.
- Арилжааны банканд төсвийн байгууллагын ажилчдын цалин олгох харилцах данс, Монголбанк, Сангийн яамны зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүй нээсэн данснууд байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,248.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 254.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	993,324.8	1,247,781.3	254,456.5	100.0
Төрийн сангийн харилцах	244,746.8	112,922.4	(131,824.4)	9.0
Арилжааны банкны харилцах	748,565.7	1,134,851.9	386,286.2	91.0
Бусад төсөл, нөөцийн харилцах	11.4	5.4	(6.0)	
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.9	1.6	0.7	
Замд яваа мөнгөн хөрөнгө	700.0	575.0	(125.0)	-
Дүн	994,024.8	1,248,356.3	254,331.5	100.0
<i>Үүнээс, сангийн төрлөөр</i>				
Тэтгэврийн даатгалын сангийн харилцах	467,076.5	452,928.7	(14,147.8)	36.3
Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах	117,539.0	202,169.6	84,630.6	16.2
ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах	362,057.6	577,784.4	215,726.8	46.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах	38,287.2	5,168.7	(33,118.5)	0.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах	1,541.1	175.4	(1,365.7)	-
Төвлөрсөн харилцах	6,652.5	9,547.4	2,894.9	0.8
Үйл ажиллагааны харилцах	170.9	7.1	(163.8)	-
Замд яваа мөнгө	700.0	575.0	(125.0)	-
Дүн	994,024.8	1,248,356.3	254,331.5	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 254.3 тэрбум төгрөгөөр өссөн нь ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах 215.7 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн харилцах 84.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Харин тэтгэврийн даатгалын сангийн харилцах 14.1 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сан 33.1 тэрбум төгрөгөөр буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Чингис хаан банк дахь Нийгмийн даатгалын төв сангийн мөнгөн хөрөнгийн 94.9 тэрбум төгрөгийн чөлөөт үлдэгдэл эрсдэлтэй хэвээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 161.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 9.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	88,455.4	66,384.9	(22,070.5)	41.2
Арилжааны банкин дахь харилцах	81,910.5	94,672.1	12,761.6	58.8
Дүн	170,365.9	161,057.0	(9,308.9)	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 22.1 тэрбум төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан нь үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 94.7 тэрбум төгрөг арилжааны банк дахь харилцахад, 66.4 тэрбум төгрөг төрийн сангийн мөнгөн хөрөнгийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181 /ШШ2020/02421 дүгээр шийдвэрээр Чингис хаан банк дахь ЭМДС-ийн харилцах дансны 27.9 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тус банкаар төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч шийдвэрийг хэрэгжүүлээгүй, 2023 оны жилийн эцсийн байдлаар 30.9 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэл эрсдэлтэй хэвээр байна.

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
14

Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9,085.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4,453.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Улс, орон нутгийн ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	57,015.6	65,932.9	8,917.3	0.7
Банканд байгаа бэлэн мөнгө	4,457,333.1	8,749,191.4	4,291,858.3	96.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	32,502.8	65,534.7	33,031.9	0.7
Хадгаламж	85,611.7	205,145.8	119,534.1	2.3
Дүн	4,632,463.2	9,085,804.8	4,453,341.6	100.0
<i>Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр</i>				
ОНТЕЗ	859,800.5	1,434,170.4	574,369.9	15.8
УТЕЗ	3,772,662.7	7,651,634.4	3,878,971.7	84.2
Дүн	4,632,463.2	9,085,804.8	4,453,341.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 96.2 хувь буюу 7,361.1 тэрбум төгрөгийг харилцах данс дахь мөнгөн хөрөнгө, 2.7 хувь буюу 205.1 тэрбум төгрөгийг хадгаламж, 0.9 хувь буюу 65.3 тэрбум төгрөгийг касст байгаа бэлэн мөнгө, 0.3 хувь буюу 20.1 тэрбум төгрөгийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,878.9 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө 2,322.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал: Засгийн газрын "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай" 2023 оны 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласнаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн орлого 1,178.8 тэрбум төгрөг, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д байршуулсан барьцаа дэнчин 880.9 тэрбум төгрөг, Төрийн банк ХК-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл 554.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийт 9.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан /ЭМС 3.2 тэрбум төгрөг, ШЕЗ 3.0 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 2.7 тэрбум төгрөг, ГХС 0.1 тэрбум төгрөг/;
- Орлогын төлөвлөгөө тасалсан, улсын төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлого, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй, орлого бүртгээгүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан 2.9 тэрбум төгрөг /Соёлын сайд 1.0 тэрбум төгрөг, ХНХС 0.6 тэрбум төгрөг, БШУС 0.4 тэрбум төгрөг, ШЕЗ 0.3 тэрбум төгрөг, ТАЗ 0.3 тэрбум төгрөг, БХБС 0.2 тэрбум төгрөг бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Баталсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан 13.9 тэрбум төгрөг /БШУС 4.9 тэрбум төгрөг, МУЕП 3.0 тэрбум төгрөг, ХНХС 2.3 тэрбум төгрөг, УУХҮС 1.1 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.9 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.5 тэрбум төгрөг, ЭМС 0.5 тэрбум төгрөг, ЭХС 0.4 тэрбум төгрөг, ШСХ 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй 11.3 тэрбум төгрөг /УУХҮС 5.7 тэрбум төгрөг, БШУС 3.3 тэрбум төгрөг, ХНХС 1.0 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.5 тэрбум төгрөг, ЭМС 0.3 тэрбум төгрөг, ЭХС 0.2 тэрбум төгрөг, БХБС 0.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 256.3 тэрбум төгрөг /УУХҮС 234.6 тэрбум төгрөг, Сангийн сайд 12.0 тэрбум төгрөг, БХБС 3.1 тэрбум төгрөг, БШУС 1.9 тэрбум төгрөг, ХНХС 1.3 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.7 тэрбум төгрөг, ХЗДХС 0.6 тэрбум төгрөг, БОАЖС 0.6 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 0.3 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, МУЕП 0.2 тэрбум төгрөг, ЦХХС 0.2 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.1 тэрбум төгрөг, ЗТХС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/;
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд 133.3 тэрбум төгрөгийг байршуулсан /НДС 94.9 тэрбум төгрөг, ЭМДС 30.9 тэрбум төгрөг, ХХААХҮС 7.5 тэрбум төгрөг/

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,434.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 574.4 тэрбум төгрөгөөр буюу 66.8 хувиар өссөн байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 904.9 тэрбум төгрөг буюу 63.1 хувийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын, 261.6 тэрбум төгрөг буюу 18.2 хувийг төрийн сангийн, 181.0 тэрбум төгрөг буюу 12.6 хувийг төсөвт байгууллагын, 86.7 тэрбум төгрөг буюу 6.0 хувийг төсөл сангийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд 0.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан /Баян-Өлгий аймаг 0.2 тэрбум төгрөг, Дундговь аймаг ТЭЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих 0.2 тэрбум төгрөгийн түрээсийн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй /Сүхбаатар аймаг 0.1 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.1 тэрбум төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 1.3 тэрбум төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Нийслэл 0.6 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 0.4 тэрбум төгрөг, Төв аймаг 0.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Баян-Өлгий аймаг мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, байгууллагын эд хариуцагчийн дансаар бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн, кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг 0.2 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн;
- Баталсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй 1.9 тэрбум төгрөгийг зарцуулсан /Завхан аймаг 0.8 тэрбум төгрөг, Булган аймаг 0.4 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.3 тэрбум төгрөг, Өмнөговь аймаг 0.2 тэрбум, бусад ТЭЗ аймаг 0.2 тэрбум төгрөг/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн төлбөрийг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй 0.4 тэрбум төгрөг /Төв аймаг 0.2 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 0.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.1 тэрбум төгрөг/.

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 418.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 32.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Богино хугацаат хөрөнөө оруулалт, байгууллагаар

Байгууллага	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Боловсролын зээлийн сан	305.9	144.5	(161.4)	0.1
Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент	426.0	500.0	74.0	0.1
Төрийн банк ХК	450,766.4	418,236.6	(32,529.8)	99.8
Дүн	451,498.3	418,881.0	(32,617.3)	100.0

Эх сурвалж: Төсвийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн банк ХК тайлант онд Монголбанкны 4 долоон хоногийн хугацаатай 8,575.3 тэрбум төгрөгийн үнэт цаасыг худалдан авч, 8,607.8 тэрбум төгрөгийн үнэт цаасны хугацаа дуусаж төлсөнтэй холбоотойгоор богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 32.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Мөн Боловсролын зээлийн сангийн эзэмшиж буй энгийн векселээс тайланд онд 0.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

4.3 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 6,445.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 111.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,046.2	3,312.4	266.2	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	444,434.9	496,125.8	51,690.9	7.7
Татаас, санхүүжилтийн авлага	383,783.4	198,317.9	(185,465.5)	3.1
Зээлийн хүүгийн авлага	365,286.2	233,272.1	(132,014.1)	3.6
Дансны авлага /ТӨҮГ/	433,649.6	1,106,546.7	672,897.1	17.2
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	273,743.9	325,289.7	51,545.8	1.3

СНАГ-2024/1-НА/СТА-ЗГСНТ

01
 АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
 16

Аудитын санал дүгнэлт
 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан
 Үндсэн мэдээлэл
 Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн
 Аудитын илрүүлэлт
 Бусад асуудал
 Дүгнэлт, зөвлөмж

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Бусад авлага	1,786,586.0	1,548,695.8	(237,890.2)	24.0
Зээлийн авлага	2,643,315.6	2,533,671.5	(109,644.1)	39.3
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,201,068.6	1,192,814.7	(8,253.9)	18.5
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,442,247.0	1,340,856.9	(101,390.1)	20.8
Дүн	6,333,845.8	6,445,231.9	111,386.1	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,295,473.9	2,711,228.2	415,754.3	42.1
Төрийн сан	1,687,440.5	1,664,181.6	(23,258.9)	25.8
Төсөвт байгууллага	1,123,010.1	1,038,928.5	(84,081.6)	16.1
Төсөл/Сан	1,227,921.3	1,030,893.6	(197,027.7)	16.0
Дүн	6,333,845.8	6,445,231.9	111,386.1	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлийн 39.3 хувийг зээлийн, 24.0 хувийг бусад, 17.2 хувийг дансны, 7.7 хувийг төлбөртэй үйлчилгээний, 5.0 хувийг татвар, НДШ-ийн, 3.6 хувийг зээлийн хүүгийн, 3.1 хувийг татаас санхүүжилтийн, 0.1 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага эзэлж байна.

Тайлант онд дансны авлага 672.9 тэрбум төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 51.7 тэрбум төгрөг, татвар, НДШ-ийн авлага 51.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дансны авлага 672.9 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрсний борлуулалтын авлага 305.7 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн биржийн дэнчингийн авлага 238.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын үлдэгдэл 1,655.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 24.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №10. Төв төрийн сангийн авлага

/сая төгрөгөөр/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд зэлэх хувь
Зээлийн хүүгийн авлага	111,686.0	90,689.4	(20,996.6)	5.5
Бусад авлага	133,450.7	243,518.5	110,067.8	14.7
Зээлийн авлага	1,434,468.5	1,320,939.7	(113,528.8)	79.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	7,921.7	7,904.7	(17.0)	0.5
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,426,546.8	1,313,035.0	(113,511.8)	79.3
Дүн	1,679,605.2	1,655,147.6	(24,457.6)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан

Төв төрийн сангийн авлага 24.5 тэрбум төгрөгөөр буурсан нь бусад авлага 110.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 113.5 тэрбум төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 21.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийснээс шалтгаалсан байна.

Төв төрийн сангийн санхүүгийн тайланд Улаанбаатар хотын нийтийн тээврийн автобус төслийн арга хэмжээний худалдан авалттай холбоотой хөрөнгө оруулалтын санхүүжилт 76.5 тэрбум төгрөгийг Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчаас авах авлагаар бүртгэн тайлагнасан боловч хоорондын тооцоо үүсгэж, баталгаажуулаагүй бөгөөд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй байна. Дээрх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид олгосон 76.5 тэрбум төгрөгийг Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэж тайлагнасан тул төв төрийн сангийн тайланд авлагаар бүртгэж байгаа нь Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгөд давхардуулан илэрхийлсэн байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын үлдэгдэл 1,313.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 113.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт №11. Төв төрийн сангийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд зэлэх хувь
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	517,090.9	748,506.8	231,415.9	57.01
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон	273,408.4	199,947.8	(73,460.6)	15.23
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон	636,047.5	364,580.3	(271,467.2)	27.77
Дүн	1,426,546.8	1,313,034.9	(113,511.9)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын 57.0 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт, 15.2 хувийг төрийн өмчит аж ахуйн нэгжид, 27.8 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл тус тус эзэлж байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 113.5 тэрбум төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 209.8 тэрбум төгрөгийн үндсэн зээл болон хүүгийн төлбөр төлөгдсөн, 304.1 тэрбум төгрөгийн ашиглалт гарснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЭХС: Гадаад зээлээр санхүүжүүлсэн 2018-2022 онд хэрэгжиж дууссан "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл"-ийн нийт 176.7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, авлагаар бүртгээгүй;
- БХБС: Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний дагуу 2012 онд Бэрэн групп ХХК-д 173.6 тэрбум төгрөг, Цагаан хуаран консалтинг ХХК-д олгосон 65.6 тэрбум төгрөг, нийт 239.2 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлт хийгдээгүй, маргаан үүссэн асуудлыг гэрээний дагуу арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй;
- Төсвийн 26 ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэрэгжүүлж байгаа төслүүдийн 2,821.0 тэрбум төгрөгийн зээлийн гэрээний авлагын үлдэгдэлд ногдох хугацаа хэтэрсэн 751.9 тэрбум төгрөгийн авлага бүртгэлтэй Үүнээс: 2023 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж баталгаажуулсан 2,286.0 тэрбум төгрөгт ногдох хугацаа хэтэрсэн авлага 387.3 тэрбум төгрөг, тооцоог нийлэх боломжгүй нөхцөл байдалтай-534.9 тэрбум төгрөгт ногдох хугацаа хэтэрсэн авлага 364.6 төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэл 1,038.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 84.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №12. Төсөвт байгууллагын авлага /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд зэлэх хувь
Орон нутаг	136,966.5	149,434.2	12,467.7	14.4
Улсын төсөв	986,043.6	889,494.3	(96,549.3)	85.6
Дүн	1,123,010.1	1,038,928.5	(84,081.6)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 85.6 хувийг улсын төсвийн, 14.4 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын авлага эзэлж байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн авлагын үлдэгдэлд ХХААХҮС 35.8 хувийг, БШУС 31.0 хувийг, ХНХС 13.8 хувийг, ХЗДХС 8.5 хувийг, бусад ТЕЗ 11.3 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн авлагын үлдэгдэлд Өвөрхангай 15.7 хувийг, Увс 13.2 хувийг, Сэлэнгэ 9.4 хувийг, Нийслэл 8.7 хувийг, Ховд 6.2 хувийг, бусад ОНТЕЗ 46.8 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, шүүхийн шийдвэр хэрэгжүүлээгүй нийт 63.3 тэрбум төгрөг /ХНХС 23.0 тэрбум төгрөг, Сангийн сайд 17.4 тэрбум төгрөг, ХХААХҮС 5.5 тэрбум төгрөг, ЦХХХС 4.7 тэрбум төгрөг, ХЗДХС 4.3 тэрбум төгрөг, БОАЖС 2.0 тэрбум төгрөг, ЭМС 0.7 тэрбум төгрөг, Төв 2.5 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.3 тэрбум төгрөг, НЗДТГ 1.5 тэрбум төгрөг, Говь-Алтай 0.4 тэрбум төгрөг, Дундговь аймаг 0.4 тэрбум төгрөг, Хэнтий аймаг 0.2 тэрбум төгрөг, Сүхбаатар аймаг 0.2 тэрбум төгрөг, Архангай аймаг 0.1 тэрбум төгрөг, Хөвсгөл аймаг 0.1 тэрбум төгрөг/;

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

- Авлагыг бүртгэж, тайлагнаагүй нийт 9.7 тэрбум төгрөг /ХХААХҮС 8.6 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.4 тэрбум төгрөг, Булган аймаг 0.3 тэрбум төгрөг, Дорнод аймаг 0.2 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.2 тэрбум төгрөг/;
- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй авлага нийт 296.7 тэрбум төгрөг /БШУС 146.7 тэрбум төгрөг, ХХААХҮС 99.4 тэрбум төгрөг, ХНХС 37.0 тэрбум төгрөг, НЗДТГ 12.9 тэрбум төгрөг, Баян-Өлгий аймаг 0.6 тэрбум төгрөг, Булган аймаг 0.1 тэрбум төгрөг/;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд нийт 2.5 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн /БШУС 0.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.1 тэрбум төгрөг, БХБС 0.1 тэрбум төгрөг, ОНБТСС 0.1 тэрбум төгрөг, Ерөнхий сайд 0.5 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 0.8 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 0.6 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.2 тэрбум төгрөг/.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 2,711.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 415.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №13. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага /сая төгрөгөөр/

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	200,936.7	197,126.2	(3,810.5)	7.3
Төрийн өмчит хуулийн этгээд	2,094,537.2	2,514,102.0	419,564.8	92.7
Дүн	2,295,473.9	2,711,228.2	415,754.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 92.7 хувийг төрийн өмчит, 7.3 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн авлагын үлдэгдлийн 24.0 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 22.1 хувийг Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, 8.6 хувийг Монгол улсын хөгжлийн банк ХХК, 7.6 хувийг Тавантолгой төмөр зам ХХК, 5.4 хувийг Монголын төмөр зам ТӨХК, 2.6 хувийг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, 2.4 хувийг МИАТ ТӨХК, 2.1 хувийг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, 2.1 хувийг Төрийн банк ХК, 2.1 хувийг Иргэний нисэхийн ерөнхий газар, 2.0 хувийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, 11.4 хувийг бусад төрийн өмчит хуулийн этгээдийн авлага эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн авлагын өсөлтөд Эрдэнэс Тавантолгой ХК 567.9 тэрбум төгрөг, Монголын төмөр зам ТӨХК 79.6 тэрбум төгрөг, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК 54.9 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК 27.4 тэрбум төгрөг, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК 19.9 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 13.6 тэрбум төгрөг, Төрийн банк ХК 11.9 тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 10.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын үлдэгдлийн 33.7 хувийг Таван толгой ХК, 11.0 хувийг Нийслэлийн орон сууцны корпораци ХК, 9.9 хувийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ, 9.3 хувийг Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК, 6.4 хувийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, 3.1 хувийг Алтай орон сууцны корпораци ААТҮГ, 2.2 хувийг Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ, 2.0 хувийг УБ зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ, 22.3 хувийг бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага эзэлж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага өмнөх оноос 3.8 тэрбум төгрөгөөр буурахад Тавантолгой ХК-ийн борлуулалтын авлага 49.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн 51.2 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шүүхийн шийдвэр хэрэгжүүлээгүй нийт 187.6 тэрбум төгрөг /Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК 101.8 тэрбум төгрөг, Цемент шохой ТӨХК 45.7 тэрбум төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК 14.6 тэрбум төгрөг, МУБИС 7.7 тэрбум төгрөг, Монголын цахилгаан холбоо ХК 4.1 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК 3.9 тэрбум төгрөг, Монголын төмөр зам ТӨХК 2.9 тэрбум төгрөг, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ 2.3 тэрбум төгрөг, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК 0.8 тэрбум төгрөг, ХААИС 0.7 тэрбум төгрөг, Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК 0.4 тэрбум төгрөг, МУИС 0.3 тэрбум төгрөг, Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК 0.3 тэрбум төгрөг, бусад 2.1 тэрбум төгрөг /;

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Авлага дансны үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн нийт 1.8 тэрбум төгрөг /Тавантолгой төмөр зам ХХК 1.3 тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 0.3 тэрбум төгрөг, Монросцветмет ХХК 0.2 тэрбум төгрөг/;
- Олон жилийн насжилттай, эзэлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй нийт 28.4 тэрбум төгрөг /Төрийн орон сууцны корпораци ТӨХХК 21.4 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК 3.2 тэрбум төгрөг, ИНЕГ 2.0 тэрбум төгрөг, ИНУТ 0.8 тэрбум төгрөг, ШУТИС 0.8 тэрбум төгрөг, АТҮТ 0.1 тэрбум төгрөг, ЭХҮТ 0.1 тэрбум төгрөг /;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд нийт 0.4 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн /Авто импекс ХК 0.3 тэрбум төгрөг, Буянт-Ухаа спортын ордон 0.1 тэрбум төгрөг /;
- МИАТ ТӨХК нь дайны нөхцөлтэй байгаа орны 1 харилцагчийн 0.2 тэрбум төгрөг, Ковидын үеийн нислэгийн зардал 2 харилцагчийн 0.4 тэрбум төгрөг, нийт 0.6 тэрбум төгрөгийг ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлээгүй;
- Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК борлуулалтын авлагын үлдэгдэл 1.5 тэрбум төгрөгөөс найдваргүй авлагын нөөц байгуулаагүй.

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, АУДИТЫН ДҮН

Аудитын илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

Нийгмийн даатгалын сангийн авлага

Авлага дансны үлдэгдэл 680.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 117.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №14. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.3	0.3	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	354,357.7	399,910.6	45,552.9	58.8
Татаас, санхүүжилтийн авлага	359,832.7	197,940.9	(161,891.8)	29.1
Бусад авлага	83,365.7	82,654.2	(711.5)	12.1
Дүн	797,556.1	680,506.0	(117,050.1)	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын сангийн татаас, санхүүжилтийн авлага 161.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэлд Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөг, олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах 6.4 тэрбум төгрөг, улсын байцаагчийн актаар тогтоосон шимтгэлийн нөхөн төлбөр болон торгуулийн 0.1 тэрбум төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- НДС-ийн нийт 74.6 тэрбум төгрөгийн барагдаагүй авлага, үүнээс олон жилийн насжилттай, эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 6.4 тэрбум төгрөг, Капитал банкны барагдаагүй авлагын үлдэгдэл 68.2 тэрбум төгрөг;
- Баянзүрх дүүргийн НДХ-ийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийт 9.0 тэрбум төгрөгийн барагдаагүй авлага, үүнээс ААНБ-ын төлбөрийн актын барагдаагүй авлага 0.1 тэрбум төгрөг, НДШ-ийн авлага 8.6 тэрбум төгрөг, бусад барагдаагүй авлага 0.2 тэрбум төгрөг;
- Төв аймгийн НДХ-ийн авлага 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Налайх дүүргийн НДХ 0.2 тэрбум төгрөг, Говь-сүмбэр аймгийн НДХ 0.1 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны үлдэгдэл 80.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 25.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №15. Авлагын үлдэгдэл /сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Татаас, санхүүжилтийн авлага	23,943.7	495.8	(23,447.9)	0.6
Байгууллагаас авах авлага	82,263.0	79,731.5	(2,531.5)	99.3
Дүн	106,206.7	80,227.3	(25,979.4)	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авах татаас санхүүжилтийн 23.9 тэрбум төгрөг, Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 1.2 тэрбум төгрөг, НДЕГ-аас авах 1.4 тэрбум төгрөгийн авлагыг тус тус барагдуулсан байна.

01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Авлага дансны үлдэгдэлд Капитал банкны эрх хүлээн авагчаас 78.5 тэрбум төгрөг, Хаппи веритас ХХК-ийн Интерферон альфа эмнэлгээс авах 0.9 тэрбум төгрөг, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 0.5 тэрбум төгрөг, НДЕГ-аас авах ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн 0.2 тэрбум төгрөг, Монгол рокестр ХХК-аас авах түрээсийн 0.1 тэрбум төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцэст 0.9 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 5,137.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,523.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №16. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,516,898.0	4,220,771.9	1,704,073.9	82.2
Төрийн сан	756,360.8	534,051.6	(222,309.2)	10.4
Төсөвт байгууллага	327,807.6	0367,955.2	40,147.6	7.1
Төсөл/сан	13,616.2	14,842.1	1,225.9	0.3
Дүн	3,614,482.6	5,137,620.8	1,523,138.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 82.2 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 10.4 хувийг төсөвт байгууллагын, 7.2 хувийг төсөл, сангуудын, 0.3 хувийг төрийн сангийн урьдчилгаа эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урьдчилгаа дансны үлдэгдэлд Эрдэнэс Тавантолгой ХК 2,155.0 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 1,478.4 тэрбум төгрөг, Монголросцветмет ТӨҮГ 118.3 тэрбум төгрөг, бусад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 469.0 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Урьдчилгаа дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гэрээний биелэлтэд хяналт тавиагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй 7.7 тэрбум төгрөг /БШУС 0.7 тэрбум төгрөг, ЭМС 0.4 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.1 тэрбум төгрөг, УУХҮС 0.1 тэрбум төгрөг, Ховд аймаг 5.7 тэрбум төгрөг, Нийслэл 0.7 тэрбум төгрөг/;
- Урьдчилгаа төлбөрийг тайлант ногдох зардлаар хүлээн зөвшөөрөөгүй, дансны бичилт буруу бүртгэсэн 0.7 тэрбум төгрөг / ХНХС 0.5 тэрбум төгрөг, ЭХС 0.2 тэрбум төгрөг/;
- Он удаан жил болсон урьдчилгааг барагдуулах арга хэмжээ аваагүй, найдваргүй болох эрсдэлтэй 15.3 тэрбум төгрөг /БООАЖС 10.1 тэрбум төгрөг, УУХҮС 5.2 тэрбум төгрөг/;
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ОНХС 2022 онд хөрөнгө оруулалтын зардлаас хийгдсэн 0.1 тэрбум төгрөгийн ажлыг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, хөрөнгө оруулалтын ажлыг дуусгах арга хэмжээ аваагүй.

4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл 3,651.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 377.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №17. Бараа материал данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,865,067.7	2,143,620.8	278,553.1	58.7
Төсөвт байгууллага	1,337,107.0	1,438,688.2	101,581.2	39.4
Төсөл/сан	72,424.0	69,642.1	(2,781.9)	1.9
Дүн	3,274,598.7	3,651,951.1	377,352.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 377.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материалын өсөлт голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулах үндсэн технологийн материалын нөөц 111.2 тэрбум төгрөг;

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Эрдэнэс алт ресурс ХХК-ийн баяжмалын үлдэгдэл 66.9 тэрбум төгрөг;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 46.7 тэрбум төгрөг, сэлбэг материалын нөөц 10.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалыг хэрэглээнээс илүү бэлтгэсэн, хадгалалтын хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, эргэлт удааширсан 73.8 тэрбум төгрөг /УУХҮС 65.9 тэрбум төгрөг, ЭХС 4.4 тэрбум төгрөг, БХБС 1.8 тэрбум төгрөг, ЭМС 1.3 тэрбум төгрөг, ХНХС 0.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.1 тэрбум төгрөг/;
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, шууд зардалд тусгасан 2.8 тэрбум төгрөг /БШҮС 0.5 тэрбум төгрөг, ХНХС 0.1 тэрбум төгрөг, Баянхонгор аймаг 2.0 тэрбум төгрөг, Нийслэл 0.2 тэрбум төгрөг/;
- Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй 48.5 тэрбум төгрөг /ЭМС 0.6 тэрбум төгрөг, ХНХС 0.4 тэрбум төгрөг, НДС 0.1 тэрбум төгрөг, Өмнөговь аймаг 47.2 тэрбум төгрөг, Төв аймаг аймаг 0.1 тэрбум төгрөг, Хэнтий аймаг 0.1 тэрбум төгрөг/;
- Анхан шатны баримт, бүртгэл тайлагналтай холбоотой 9.5 тэрбум төгрөг /ЭМС 4.2 тэрбум төгрөг, УУХҮС 2.6 тэрбум төгрөг, БОАЖС 1.3 тэрбум төгрөг, ХНХЯ 0.2 тэрбум төгрөг, ХХААХҮЯ 0.1 тэрбум төгрөг, Соёлын яам 0.1 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 0.5 тэрбум төгрөг, Өвөрхангай аймаг 0.4 тэрбум төгрөг, Сүхбаатар аймаг 0.1 тэрбум төгрөг/

НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 210.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №18. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	11,134.3	77,018.2	65,883.9	36.6
Төсөвт байгууллага	125,065.5	132,694.2	7,628.7	63.2
Төсөл/сан	74,433.3	339.1	(74,094.2)	0.2
Дүн	210,633.1	210,051.5	(581.6)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2023 оны 269 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгаж, сангийн 60.1 тэрбум төгрөгийн нөөцийн барааг Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК-д шилжүүлсэн байна.

4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 11,464.6 тэрбум болж, өмнөх оноос 2,900.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №19. Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,248,721.4	1,197,958.6	(50,762.8)	10.4
Төсөвт байгууллага	5,144,635.9	7,013,704.0	1,869,068.1	61.2
Төрийн сан	27,468.9	28,452.0	983.1	0.3
Төсөл/сан	2,143,372.8	3,224,481.0	1,081,108.2	28.1
Дүн	8,564,199.0	11,464,595.6	2,900,396.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 2,900.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь төсөвт байгууллага болон төсөл, сангийн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Төсөвт байгууллагын бусад эргэлтийн хөрөнгө 1,869.1 тэрбум төгрөгөөр өссөн нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээний үүргийн биелэлт хангагдах хүртэл олгосон санхүүжилтийг эргэлтийн хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн 42 төсөл, хөтөлбөрийн нэгжийн тоног төхөөрөмж, зам гүүр, барилга байгууламж, ТЭЗҮ, зураг төслийн зөвлөх үйлчилгээний зардлуудыг хуримтлуулж бүртгэсэнээс шалтгаалан 979.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аудитын санал
дүгнэлт

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

Аудитын илрүүлэлт:

- ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын концессын гэрээгээр 183.6 тэрбум төгрөгийн өртөгтэй Төмөртэйн Хандгайт өртөөний 22.9 км төмөр зам, ачиг буулгах терминал, авто замын барилгыг Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 491 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2015 оны 02/18/15 дугаар "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах акт"-аар байнгын ашиглалтад оруулсан боловч Захиргааны хэргийн шүүх дээр маргаантай байгаа тул хөрөнгийн бүртгэл өнөөг хүртэл тодорхойгүй;
- ЭМС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад өмнөх онд хуваарилсан 18.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн, улсын комисс хүлээж авсан 2.8 тэрбум төгрөгийн барилгыг бүртгэх ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулаагүй, 2.5 тэрбум төгрөгийн өртөгтэй хэрэгжиж дууссан их засварын ажлуудыг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- ЦХХС-ын хэрэгжүүлсэн 41 төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон 10.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;
- ЭХС-ын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд хэрэгжиж дууссан 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг улсын комисс актаар хүлээн авсан боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- ХХААХҮС-ын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, улсын комисс хүлээн авсан хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 2.4 тэрбум төгрөгийн 4 барилга, байгууламж бүртгэлтэй байна.

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 11,769.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 211.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №20. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	56,896.7	60,011.8	3,115.1	0.51
Үнэт цаас	3,506,320.8	3,270,019.7	(236,301.1)	27.78
Урт хугацаат зээл	7,995,282.0	8,439,830.7	444,548.7	71.71
Дүн	11,558,499.5	11,769,862.2	211,362.7	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,194,590.7	9,152,091.6	(42,499.1)	77.8
Төрийн сан	2,261,596.9	2,519,863.9	258,267.0	21.4
Төсөвт байгууллага	57,311.9	57,906.7	594.8	0.5
Төсөл/Сангууд	45,000.0	40,000.0	(5,000.0)	0.3
Дүн	11,558,499.5	11,769,862.2	211,362.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 77.8 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 21.4 хувийг төрийн сангийн, 0.5 хувийг төсөвт байгууллагын, 0.3 хувийг төсөл сангуудын хадгаламж, үнэт цаас, урт хугацаат зээл эзэлж байна.

Үнэт цаас: Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь Засгийн газрын болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 492.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны эргэн төлөлт хийсэн.

Урт хугацаат зээл: Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага 356.4 тэрбум төгрөгөөр, урт хугацаат хөрөнгө оруулалт 80.0 тэрбум төгрөгөөр, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 8.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төрийн банк ХК-ийн хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оноос 442.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь урт хугацаат зээлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 55,521.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3,186.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №21. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	59,832.1	45,966.5	(13,865.6)	0.1

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Биет хөрөнгө	27,443,237.1	29,965,023.6	2,521,786.5	54.0
Биет бус хөрөнгө	18,747,039.2	19,086,188.1	339,148.9	34.4
Бусад хөрөнгө	6,084,996.9	6,424,198.4	339,201.5	11.5
Дүн	52,335,105.3	55,521,376.6	3,188,271.3	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	35,709,804.6	38,071,919.4	2,362,114.8	31.0
Төсөл/сан	327,096.3	232,017.2	(95,079.1)	0.4
Төсөвт байгууллага	16,298,204.4	17,217,440.0	919,235.6	68.6
Дүн	52,335,105.3	55,521,376.6	3,188,271.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3,186.3 тэрбум төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, орон сууц 1,400.7 тэрбум төгрөг, дуусаагүй барилга, байгууламж 1,383.5 тэрбум төгрөг, машин тоног төхөөрөмж 788.9 тэрбум төгрөг, бусад биет бус хөрөнгө 416.8 тэрбум төгрөг, бусад эргэлтийн бус хөрөнгө 354.8 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд 29,965.0 тэрбум төгрөг буюу 54.0 хувийг биет хөрөнгө, 19,086.2 тэрбум төгрөг буюу 34.4 хувийг биет бус хөрөнгө, 6,424.2 тэрбум төгрөг буюу 11.5 хувийг бусад хөрөнгө, 46.0 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг газар тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Жиглийн эцсийн хөрөнгийн тооллого хийж баталгаажуулаагүй, өмч хамгаалах комисс байгуулаагүй, зарим хөрөнгийг тооллогод хамруулаагүй, биетээр оршин байхгүй 803.0 тэрбум төгрөг /УТЕЗ: УУХҮС 91.3 тэрбум төгрөг, ХНХС 12.6 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 8.4 тэрбум төгрөг, Соёлын сайд 8.0 тэрбум төгрөг, БШУС 7.5 тэрбум төгрөг, ЭМС 3.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 2.9 тэрбум төгрөг, БХБС 1.6 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг, ОНТЕЗ: Өмнөговь аймаг 653.0 тэрбум төгрөг, Булган аймаг 6.8 тэрбум төгрөг, Өвөрхангай аймаг 3.8 тэрбум төгрөг, Төв аймаг 1.8 тэрбум төгрөг, Нийслэл 1.1 тэрбум төгрөг, бусад аймаг 0.8 тэрбум төгрөг/;
- Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, төсвийн хөрөнгөөр төлөвлөөгүй хөрөнгө худалдан авсан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн 833.3 тэрбум төгрөг /УТЕЗ: ЭХС 260.2 тэрбум төгрөг, БХБС 81.8 тэрбум төгрөг, ЭМС 21.7 тэрбум төгрөг, ЦХХХС 5.2 тэрбум төгрөг, БШУС 1.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.9 тэрбум төгрөг, ОНТЕЗ: Өмнөговь аймаг 4.1 тэрбум төгрөг, Булган аймаг 3.2 тэрбум төгрөг, Ховд аймаг 2.6 тэрбум төгрөг, бусад аймаг 1.9 тэрбум төгрөг/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй 57.6 тэрбум төгрөг /УУХҮС 14.5 тэрбум төгрөг, ХХААХҮС 9.8 тэрбум төгрөг, ХНХС 7.8 тэрбум төгрөг, ЗТХС 7.2 тэрбум төгрөг, ЦХХХС 5.7 тэрбум төгрөг, БШУС 5.0 тэрбум төгрөг, БОАЖС 1.9 тэрбум төгрөг, Говьсүмбэр аймаг 1.7 тэрбум төгрөг, ҮСХ 1.4 тэрбум төгрөг, Төв аймаг 1.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.4 тэрбум төгрөг/;
- Эрх бүхий дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн 180.8 тэрбум төгрөг /Сангийн сайд 170.5 тэрбум төгрөг, ЭМС 3.7 тэрбум төгрөг, Өмнөговь аймаг 2.1 тэрбум төгрөг, БШУС 1.5 тэрбум төгрөг, ЭХС 1.4 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.6 тэрбум төгрөг/;
- Газар эзэмших эрхийг үнэлж, баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, кадастрын зураг, гэрчилгээгүй, кадастрын зургаас зөрүүтэй 307.9 тэрбум төгрөг /УУХҮС 230.6 тэрбум төгрөг, ГХС 77.1 тэрбум төгрөг, ХНХС 0.1 тэрбум төгрөг, БШУС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/.

4.9 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 55,194.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,999.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №22. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	8,631,708.1	12,747,684.0	4,115,975.9	23.1
Богино хугацаат үнэт цаас	15,575.3	512,800.2	497,224.9	0.9
Богино хугацаат зээлийн өглөг	2,373,969.9	3,199,247.0	825,277.1	5.8
Өглөг	3,872,435.0	5,790,559.8	1,918,124.8	10.5
Урьдчилж орсон орлого	2,369,727.9	3,245,077.0	875,349.1	5.9
Урт хугацаат өр төлбөр дүн	44,563,000.9	42,446,501.6	(2,116,499.3)	76.9
Урт хугацаат үнэт цаас	16,855,319.7	13,595,979.1	(3,259,340.6)	24.6
Урт хугацаат зээл	27,707,681.2	28,850,522.4	1,142,841.2	52.3
Дүн	53,194,709.0	55,194,185.6	1,999,476.6	100.0

Үүнээс, байгууллагын төрлөөр

01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ 24

Аудитын санал дүгнэлт
 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан
 Үндсэн мэдээлэл
 Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн
 Аудитын илрүүлэлт
 Бусад асуудал
 Дүгнэлт, зөвлөмж

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨҮГ болон ОНӨҮГ	20,083,387.6	21,548,424.0	1,465,036.4	73.3
Төрийн сан	31,861,476.3	32,204,354.9	342,878.6	17.1
Төсөвт байгууллага	779,613.3	824,463.0	44,849.7	2.2
Төсөл/сан	470,231.8	616,943.7	146,711.9	7.3
Дүн	53,194,709.0	55,194,185.6	1,999,476.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт өр төлбөр 1,999.4 тэрбум төгрөгөөр өссөн нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 1,465.0 тэрбум төгрөг, төрийн сангийн 342.9 тэрбум төгрөг, төсөл, сангийн 146.7 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын 44.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр 4,115.9 тэрбум төгрөгөөр өссөн нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 3,587.9 тэрбум төгрөг, төрийн сангийн 318.2 тэрбум төгрөг, төсвийн байгууллагын 223.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 2,123.0 тэрбум төгрөг, төсөвт байгууллага 178.7 тэрбум төгрөгөөр урт хугацаат өр төлбөр буурсан байна.

Төв төрийн сангийн өр төлбөр

Төв төрийн сангийн урт хугацаат өр төлбөр 65.7 тэрбум төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 310.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №23. Төрийн сангийн нийт өр, төлбөр дансны ангилал, /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	371,746.9	681,776.8	310,029.9	2.1
Богино хугацаат үнэт цаас	15,575.3	15,575.3	-	-
Богино хугацаат зээлийн өглөг	314,814.9	367,274.3	52,459.4	1.2
Урьдчилж орсон орлого	41,356.7	298,927.2	257,570.5	0.9
Урт хугацаат өр төлбөр дүн	31,442,312.0	31,508,030.5	65,718.5	97.9
Урт хугацаат үнэт цаас	11,491,917.7	10,605,117.4	(886,800.3)	32.9
Урт хугацаат зээл	19,950,394.3	20,902,913.1	952,518.8	64.9
Дүн	31,814,058.9	32,189,807.3	375,748.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл 4,951.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 5,119.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлснөөр хасагдсан байна.

Хүснэгт №24. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өглөг /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гадаад үнэт цаас	Гадаад зээл	Дотоод үнэт цаас	Дүн
Нэмэгдсэн дүн	3,370.2	1,580.9	-	4,951.1
Бонд	3,457.0			3,457.0
Зээлийн ашиглалт		1,939.0		1,939.0
Ханшийн алдагдал	(86.8)	(358.1)		(444.9)
Хасагдсан дүн	3,358.2	959.8	801.4	5,119.4
Үндсэн төлбөр	3,358.2	959.8	801.4	5,119.4
Хүүгийн төлбөр	553.0	460.0	79.7	1,092.7

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор олон улсын зах зээлд 3,457.0 тэрбум төгрөгийн "Сентчири-II", "Сентчири-III" үнэт цаасыг арилжаалсан байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-д 383.9 тэрбум төгрөг, Хадгаламжийн даатгалын корпораци ХХК-д 170.0 тэрбум төгрөг, Худалдаа, хөгжлийн банк ХХК-д 232.5 тэрбум төгрөг, бусад банк, санхүүгийн байгууллагад 15.0 тэрбум төгрөг, нийт 801.4 тэрбум төгрөгийн дотоод бондын үндсэн төлбөрийг төлжээ.

Донор орон, олон улсын банк санхүүгийн байгууллагаас 72 төслийн хүрээнд 1,939.0 тэрбум төгрөгийн гадны эх үүсвэртэй зээл авч, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 1,246.5 тэрбум төгрөг, төсвийн дэмжлэгийн зориулалтаар 692.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан.

Гадаад зээлээр хэрэгжүүлсэн 209 төсөл, хөтөлбөрийн үндсэн төлбөрт 959.5 тэрбум төгрөг, 270 төсөл, хөтөлбөрийн хүүгийн төлбөрт 460.0 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөрийн үлдэгдэл 21,548.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,465.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №25. Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	7,563,473.0	11,151,463.7	3,587,990.7	51.8
Богино хугацаат үнэт цаас	-	497,224.9	497,224.9	2.3
Богино хугацаат зээлийн өглөг	2,332,963.3	3,158,609.0	825,645.7	14.7
Өглөг	3,047,647.9	4,728,624.5	1,680,976.6	21.9
Урьдчилж орсон орлого	2,182,861.8	2,767,005.3	584,143.5	12.9
Урт хугацаат өр төлбөр дүн	12,519,914.6	10,396,960.4	(2,122,954.2)	48.2
Урт хугацаат үнэт цаас	5,363,402.0	2,990,861.7	(2,372,540.3)	13.9
Урт хугацаат зээл	7,156,512.6	7,406,098.7	249,586.1	34.4
Дүн	20,083,387.6	21,548,424.1	1,465,036.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэлд 10,396.9 тэрбум төгрөг буюу 48.2 хувийг урт хугацаат өр төлбөр, 11,151.5 тэрбум төгрөг буюу 51.8 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Өр төлбөрийн нийт 1,465.0 тэрбум төгрөгийн өсөлтөд богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Төрийн банк ХК богино хугацаат репо арилжаа хийж, Голомт банкнаас богино хугацаат эх үүсвэр татан төвлөрүүлсэн 496.7 тэрбум төгрөг, Каргилл ОУ-ын санхүүгийн үйлчилгээнээс 192.1 тэрбум төгрөг, бусад 118.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн;
- Монголын хөрөнгийн бирж ХК уул уурхайн бүтээгдэхүүний биржээр эрдэс, баялгийн бүтээгдэхүүн борлуулж эхэлсэнтэй холбоотойгоор арилжаанд оролцогчдын байршуулсан барьцаа, дэнчингийн өглөг 880.9 тэрбум төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь үнэт цаасны эргэн төлөлт хийх зорилгоор Сангийн яамнаас авсан 100.0 тэрбум төгрөгийн хадгаламж, мөн зээлийн багцын барьцаат гэрээ байгуулж, дахин санхүүжилт авсан 429.9 тэрбум төгрөг, арилжааны банкуудаас авсан санхүүжилт 15.0 тэрбум төгрөг;
- Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХК барилгын ажлын үлдэгдэл төлбөр 45.9 тэрбум төгрөг, барьцааны өглөг 15.0 тэрбум төгрөг;
- Монголын төмөр зам ТӨХК татварын өглөг 48.3 тэрбум төгрөг.

Урт хугацаат үнэт цаасны үлдэгдэл 2,372.5 тэрбум төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн Самурай үнэт цаасны 720.0 тэрбум төгрөг, Евро үнэт цаасны 1,548.0 тэрбум төгрөг, Төрийн банк ХК-ийн репо арилжааны 253.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны эргэн төлөлт хийсэн, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 383.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг богино хугацаат ангилалд шилжүүлэн бүртгэсэн.

Урт хугацаат зээлийн үлдэгдэл 249.6 тэрбум төгрөгийн өсөлтөд Төрийн банк ХК-ийн 311.7 тэрбум төгрөг, Тавантолгой түлш ХХК-ийн 265.4 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК-ийн 142.7 тэрбум төгрөг, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 77.1 тэрбум төгрөгийн зээл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, дутуу тайлагнасан 151.7 тэрбум төгрөг /ТОСК ТӨХК 30.6 тэрбум төгрөг, Цемент шохой ТӨХК 12.8 тэрбум төгрөг, МИАТ ТӨХК 8.4 тэрбум төгрөг, Монголын төмөр зам ТӨХК 6.7 тэрбум төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 6.4 тэрбум төгрөг, Багануур ХК 3.9 тэрбум төгрөг, Монголын цахилгаан холбоо ХК 2.6 тэрбум төгрөг, ШУТИС 1.9 тэрбум төгрөг, Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХК 1.8 тэрбум төгрөг, бусад 1.0 тэрбум төгрөг/;
- Татвар, НДШ-ийн өглөгийг зөрүүтэй тайлагнасан 19.0 тэрбум төгрөг /Монголын цахилгаан холбоо ХК 13.6 тэрбум төгрөг, Зээлийн батлан даалтын сан 4.5 тэрбум төгрөг, бусад 0.9 тэрбум төгрөг/;
- Олон жилийн насжилттай өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй 187.9 тэрбум төгрөг /ХААК ТӨХК 149.7 тэрбум төгрөг, ТОСК ТӨХК 30.6 тэрбум төгрөг, Эрдэнэс Сүхбаатар ХХК 7.6 тэрбум төгрөг/.

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

3.6 тэрбум төгрөг, Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 2.0 тэрбум төгрөг, бусад 2.0 тэрбум төгрөг/;

- Амгалан дулааны станц ТӨХК нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-аас 9.2 тэрбум төгрөгийн цахилгаан худалдан авч 6.1 тэрбум төгрөгийг төлж, 5.4 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байгаа нь цахилгаан нийлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны эх үүсвэрийг тасалдуулах эрсдэл үүсгэх нөхцөл бүрдсэн.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн үлдэгдэл 824.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 44.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №26. Төсвийн байгууллагын нийт өр, төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	427,929.6	651,528.9	223,599.2	79.0
Богино хугацаат зээлийн өглөг	40,515.2	40,638.0	122.8	4.9
Өглөг	319,493.0	540,541.0	221,048.0	65.6
Урьдчилж орсон орлого	67,921.4	70,349.9	2,428.4	8.5
Урт хугацаат өр төлбөр дүн	351,683.7	172,934.1	(178,749.6)	21.0
Дүн	779,613.3	824,463.0	44,849.7	100.0
Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр				
УТЕЗ	513,044.8	556,737.5	43,692.6	67.5
ОНТЕЗ	266,568.5	267,725.5	1,157.0	32.5
Дүн	779,613.3	824,463.0	44,849.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын өр төлбөрийн 67.5 хувийг улсын төсвийн ерөнхийлөн захирагч, 32.5 хувийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМС 160.4 тэрбум төгрөг, ХЗХДС 96.8 тэрбум төгрөг, Нийслэл 58.2 тэрбум төгрөг, БХБС 47.4 тэрбум төгрөг, Сангийн сайд 39.5 тэрбум төгрөг, ЗТХС 38.1 тэрбум төгрөг, БОАЖС 35.9 тэрбум төгрөг, БШУС 35.5 тэрбум төгрөг, Дархан-Уул 28.3 тэрбум төгрөг, ХНХС 21.0 тэрбум төгрөг, ХХААХҮС 10.4 тэрбум төгрөг, бусад 80.0 тэрбум төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Нийслэл 153.8 тэрбум төгрөг, ХХААХҮС 148.7 тэрбум төгрөг, Сүхбаатар 11.2 тэрбум төгрөг, Баянхонгор 3.6 тэрбум төгрөг, ХНХС 2.7 тэрбум төгрөг, Дундговь 1.9 тэрбум төгрөг, БШУС 0.2 тэрбум төгрөг, УЕП 0.1 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 15.5 тэрбум төгрөг /ОНБТСҮХ 5.3 тэрбум төгрөг, БШУС 3.2 тэрбум төгрөг, ХХААХҮС 3.2 тэрбум төгрөг, ЭМС 1.8 тэрбум төгрөг, ХНХС 0.6 тэрбум төгрөг, ХЗДХС 0.5 тэрбум төгрөг, БОАЖС 0.5 тэрбум төгрөг, ГХС 0.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Төсвийг зохистой удирдаагүй, өр төлбөр үүсгэж ажилласан 3.5 тэрбум төгрөг /ХЗДХС 2.6 тэрбум төгрөг, МУШС 0.7 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 46.3 тэрбум болж, өмнөх оноос 26.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөрийн үлдэгдэлд урьдчилж орсон орлого 84.2 хувийг, бараа үйлчилгээний зардлын өглөг 15.3 хувийг, бусад өглөг 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Бараа, үйлчилгээний зардлын өглөг дансанд хуулиар эрх үүссэн олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн 7.1 тэрбум төгрөгийн өр төлбөр, урьдчилж орсон орлого дансанд сайн дурын болон ажил олгогчийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн 39.0 тэрбум төгрөгийн илүү төлөлт бүртгэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт өр төлбөр 218.3 тэрбум болж, өмнөх оноос 157.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлийн тоо 10.9 саяд хүрч, өмнөх оноос 36.9 хувиар нэмэгдсэнээс шалтгаалан өр төлбөрийн үлдэгдэл өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 218.3 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаагаас 87.6 хувь буюу 191.2 тэрбум төгрөгийг улсын эрүүл мэндийн байгууллагуудын өглөг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны үлдэгдлээс 3.6 дахин нэмэгдсэн байна.

4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 51,500.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 11,731.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №27. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дунд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	7,744,011.2	8,029,230.9	285,219.7	15.6
Өмч	18,157,016.3	18,288,022.5	131,006.2	35.5
Нэмж төлөгдсөн капитал	18,816.5	18,816.5	-	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	8,299,306.3	9,608,439.8	1,309,133.5	18.7
Хуримтлагдсан үр дүн	(2,077,925.0)	7,962,257.5	10,040,182.5	15.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,463,186.2	7,444,269.5	(18,916.7)	14.5
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	164,949.3	149,867.0	(15,082.3)	0.3
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		(36.6)	(36.6)	(0.0)
Засгийн газрын хувь оролцооны дүн	39,769,360.8	51,500,867.1	11,731,506.3	100.0
Хяналтын бус хувь оролцоо	15,463.2	15,463.2	-	
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	39,784,824.0	51,516,330.3	11,731,506.3	

Эх сурвалж: Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 5,531.0 тэрбум төгрөг, төсөвт байгууллага 3,199.7 тэрбум төгрөг, төсөл, сан 2,014.5 тэрбум төгрөг, төрийн сан 986.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайланд төрийн болон орон нутгийн өмчит 12 хуулийн этгээдийн нийт 15.5 тэрбум төгрөгийн хяналтын бус /цөөнхийн/ хувь оролцоог тусад нь толилуулсан байна.

Төрийн өмчийн 50 болон түүнээс доош хувийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэхгүй байгаагаас төрийн нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, орлого, зардал бүрэн илэрхийлэгдэхгүй байна.

4.11 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төв төрийн сангийн санхүүгийн тайлан, улсын болон орон нутгийн 62 төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6711 төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 3496 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 2943, хязгаарлалттай 513, сөрөг 25, санал дүгнэлт гаргахаас татгалзсан 15/, 3195 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 20 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 3,845.9 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 3,794.5 тэрбум төгрөгийн 5374 алдааг залруулж, 51.4 тэрбум төгрөгийн 187 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 2,280.2 тэрбум төгрөгийн 11394 зөрчил илэрснээс 19.9 тэрбум төгрөгийн зөрчилд 2035 төлбөрийн акт, 1,786.2 тэрбум төгрөгийн зөрчилд 3861 албан шаардлага, 397.3 тэрбум төгрөгийн зөрчилд 5311 зөвлөмж, 61.9 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 205 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 175 санал хүргүүлж, 14.9 тэрбум төгрөгийн 12 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 2,011.2 тэрбум төгрөгийн 3462 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 80 төлбөрийн акт, 487.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1283 албан шаардлага, 482.8 тэрбум төгрөгийн зөрчилд 2008 зөвлөмж өгч, 487.2 тэрбум

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

040.1 тэрбум төгрөгийн төсвийн аудитын байгууллага
 01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгийн зөрчил гаргасан 95 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 85 санал хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 0.9 тэрбум төгрөгийн 6 асуудлыг шилжүүллээ.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагч, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланд аудит хийж өөрчлөлтгүй 21, хязгаарлалттай 19 дүгнэлт өглөө.

Аудитад улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 4118 төсвийн захирагч, төрийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайланд хамрагдахаас 2375 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Өөрчлөлтгүй 2092, Хязгаарлалттай 268, Сөрөг 10, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 5/, 1727 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 16 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 3,367.1 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 3,328.6 тэрбум төгрөгийн 3279 алдааг залруулж, 38.5 тэрбум төгрөгийн 141 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 1,883.3 тэрбум төгрөгийн 7131 зөрчил илэрснээс 15.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1267 төлбөрийн акт тогтоож, 1,504.8 тэрбум төгрөгийн зөрчилд 2256 албан шаардлага, 53.1 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 112 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 100 санал хүргүүлж, 295.4 тэрбум төгрөгийн зөрчилд 3498 зөвлөмж өгч, 14.8 тэрбум төгрөгийн 10 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 1,490.3 тэрбум төгрөгийн 2298 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 32 төлбөрийн акт тогтоож, 930.2 тэрбум төгрөгийн зөрчилд 772 албан шаардлага, 164.5 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 45 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 37 санал хүргүүлж, 395.5 тэрбум төгрөгийн зөрчилд 1457 зөвлөмж өгсөн.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 13, хязгаарлалттай 9 /Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Увс, Сүхбаатар/ дүгнэлт өгсөн.

Аудитад орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 2593 төсвийн захирагч, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн тайлан, зардлын дансыг хамруулахаас 1121 байгууллагад дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 851, хязгаарлалттай 245, сөрөг 15, санал дүгнэлт гаргахаас татгалзсан 10/, 1468 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан, 4 байгууллагын санхүүгийн тайланг /Хавсралт 2/ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, салбар байгууллага, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 478.8 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 465.9 тэрбум төгрөгийн 2095 алдааг залруулж, 12.9 тэрбум төгрөгийн 46 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 396.9 тэрбум төгрөгийн 4263 зөрчил илэрснээс 4.7 тэрбум төгрөгийн зөрчилд 768 төлбөрийн акт тогтоож, 281.4 тэрбум төгрөгийн зөрчилд 1605 албан шаардлага, 8.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 93 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 75 санал хүргүүлж, 101.9 тэрбум төгрөгийн зөрчилд 1813 зөвлөмж өгч, 0.1 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 520.9 тэрбум төгрөгийн 1164 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 109.9 тэрбум төгрөгийн зөрчилд 511 албан шаардлага, 322.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 50 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 48 санал хүргүүлж, 87.3 тэрбум төгрөгийн зөрчилд 551 зөвлөмж өгч, хууль хяналтын байгууллагад 0.9 тэрбум төгрөгийн 6 асуудлыг шилжүүллээ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн болон орон төрийн өмчийн оролцоотой нийт 140 хуулийн этгээдээс 137 байгууллага аудитад хамрагдаж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгээгүй.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитад хамрагдсан 137 хуулийн этгээдээс 109 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 28 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. /Өөрчлөлтгүй 68, Хязгаарлалттай 38, Сөрөг дүгнэлт 3/

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 2,183.1 тэрбум төгрөгийн 277 алдааг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 788.0 тэрбум төгрөгийн 803 зөрчил илрүүлснээс 0.9 тэрбум төгрөгийн 89 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 661.7 тэрбум төгрөгийн 286 зөрчилд албан шаардлага, 8.7 тэрбум төгрөгийн 18 зөрчилд хариуцлага тооцох 13 санал хүргүүлж, 0.5 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 116.2 тэрбум төгрөгийн зөрчилд 414 зөвлөмж өглөө.

Мөн холбогдох хууль, тогтоомжийн зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 262.5 тэрбум төгрөгийн 70 зөрчил илэрснээс, 212.2 тэрбум төгрөгийн 43 зөрчилд албан шаардлага, 38.4 тэрбум төгрөгийн 4 зөрчилд хариуцлага тооцох санал хүргүүлж, 11.9 тэрбум төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өглөө.

Хүснэгт.№28 Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллагууд

Хязгаарлалттай санал дүгнэлт

1	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	20	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо
2	Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ	21	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
3	Багануур ХК	22	Цемент шохой ТӨХК
4	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ	23	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
5	Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ	24	Эрдэнэс алт ресурс ХХК
6	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	25	Эрдэнэс Тавантолгой ХК
7	Засгийн газрын авто бааз ТӨҮГ	26	Газар-Ивээл ТӨААТҮГ
8	Иргэний нисэхийн үндэсний төв ТӨААТҮГ	27	Хөдөө аж ахуйн бирж ХХК
9	Монго Улсын Боловсролын Их сургууль	28	Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ХХК
10	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	29	Биокомбинат ТӨХХК
11	Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ	30	Зээлийн батлан даалтын сан
12	Монгол Улсын Их сургууль	31	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ
13	Монголын төмөр зам ТӨХК	32	Монголын цахилгаан холбоо ХК
14	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	33	Баруун бүсийн эрчим хүчний сүлжээ ТӨХК
15	Соёл Урлагийн Их сургууль	34	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК
16	Тавантолгой төмөр зам ХХК	35	Эрчим хүчний үндэсний төв ХХК
17	Төрийн орон сууцны корпораци ХХК	36	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
18	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨҮГ	37	Таван толгой түлш ХХК
19	Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨҮГ	38	Багануурын дулааны станц ТӨХК

Сөрөг санал дүгнэлт

1	Булган АЗЗА ТӨХК	3	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК
2	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК		

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд 12,965.6 тэрбум төгрөгийн орлого, 8,247.7 тэрбум төгрөгийн зардал, 4,717.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай тайлагнасан нь өмнөх оноос 2,155.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 75 төрийн өмчит хуулийн этгээд 5,226.3 тэрбум төгрөгийн ашигтай, 62 төрийн өмчит хуулийн этгээд 508.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Тухайлбал:

- Засгийн газрын шийдвэрээр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдаагүй хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээг ТӨХЭ-үүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлсэн;
- Тайлант онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт дүнгээр 4,717.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан боловч, тэдгээрийн 45.2 хувь нь 508.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан;
- Эрдэнэс Тавантолгой ХК нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд биш боловч Засгийн газрын шийдвэрээр Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Тавантолгой түлш ХХК, Монголын төмөр зам ТӨХК-уудад урт хугацаатай зээл олгож, жилийн төрийн худгийн байгууллага эцсийн байдлаар 2,778.6 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн;

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илгүүлт

Бусад асуудал

Дүгнэлт, зөвлөмж

01

ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

30

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэггүй төрийн өмчит хуулийн этгээдэд хяналт тавих, шаардах эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан ноогдол ашиг төвлөрүүлэх тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг 64.4 хувь, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ногдол ашиг 82.5 хувь, 2023 оны улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг 49.4 хувь, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ноогдол ашиг 75.4 хувийн хэрэгжилттэй байна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн засаглал, эрх зүйн орчинг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангахад дараах зорилтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тухайн онд багтаан боловсруулахаар тусгасан боловч хуульд тус асуудлаар өөрчлөлт ороогүй;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх 9 субъект байгаа нь Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг зөрчиж байгаа бөгөөд Чиглэлийн яам төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлснээр бодлогын удирдамжаар хангах, мониторингийн хяналт тавих чиг үүрэгтэй эрх зүйн хувьд зөрчилдөж, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид адил тэгш үйлчлэх үндсэн зарчим алдагдах нөхцөл бүрдсэн;
- Монгол Улсын Их хурлын 2022 оны "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоолоор 25 төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахыг Засгийн газарт үүрэг болгосон боловч хэрэгжилт хангалтгүй;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан боловч хэрэгжилт хангалтгүй;
- Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьд төрийг төлөөлөх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах нэгдсэн журмаар сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадвар, төрийг төлөөлөх чадамж сул, компанийн засаглалыг сайжруулахад оролцоо хангалтгүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн өмчит 428 хуулийн этгээдээс 425 байгууллага аудитад хамрагдаж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй болон татан буугдсан 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгээгүй.

Аудитад хамрагдсан 425 хуулийн этгээдээс 188 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 237 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. /Өөрчлөлтгүй 169, Хязгаарлалттай 55, Сөрөг дүгнэлт 7, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 6/

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 688.4 тэрбум төгрөгийн 475 алдаа илэрснээс 676.2 тэрбум төгрөгийн 457 алдааг аудитын явцад залруулж, 12.2 тэрбум төгрөгийн 18 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 244.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 тэрбум төгрөгийн 140 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 219.8 тэрбум төгрөгийн 306 зөрчилд албан шаардлага, 0.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 15 албан тушаалтанд хариуцлага тооцох 15 санал хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 21.7 тэрбум төгрөгийн зөрчилд 462 зөвлөмж өглөө.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 42.6 тэрбум төгрөгийн 292 зөрчил илэрснээс, 0.1 тэрбум төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28.7 тэрбум төгрөгийн 115 зөрчилд албан шаардлага, 0.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцох 7 санал хүргүүлж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 13.2 тэрбум төгрөгийн зөрчилд 161 зөвлөмж өглөө.

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт 156 төсөл, хөтөлбөрөөс төсөл хөтөлбөрийн 100 нэгжийг аудитын түүвэрт хамруулж, 56 төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа. /Өөрчлөлтгүй 48, Хязгаарлалттай 8/

Хүснэгт.№29 Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн төсөл хөтөлбөрийн нэгж

Хязгаарлалттай санал дүгнэлт

1	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2	5	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж
2	Инженер, технологийн дээд боловсрол төсөл	6	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
3	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл	7	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл
4	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл	8	Экспортыг дэмжих төсөл

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх 112 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1,224.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, 65 төсөл, хөтөлбөрт 1,206.6 тэрбум төгрөгийн ашиглалт гарчээ.

Тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх 37 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 570.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, 28 төсөл, хөтөлбөрт 316.6 тэрбум төгрөгийн ашиглалт гарсан байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа 149 төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн гүйцэтгэл 85.7 хувь байгаа боловч ажлын гүйцэтгэл нь 48.8 хувь байна. Мөн гадаад зээлээр хэрэгжиж буй 112 төсөл хөтөлбөрөөс 51-ээс доош хувийн гүйцэтгэлтэй, хэрэгжилт хангалтгүй 37 төсөл хөтөлбөр байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 271.7 тэрбум төгрөгийн 104 алдаа илэрснээс 271.4 тэрбум төгрөгийн 100 алдааг аудитын явцад залруулж, 0.3 тэрбум төгрөгийн 4 залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 247.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 188.0 тэрбум төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага, 15.2 тэрбум төгрөгийн зөрчилд 5 албан тушаалтанд хариуцлага тооцох 5 санал хүргүүлж, 44.0 тэрбум төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өглөө.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 228.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 160.5 тэрбум төгрөгийн 34 зөрчилд албан шаардлага, 12.7 тэрбум төгрөгийн 3 зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 54.7 тэрбум төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж өглөө.

Аудитын илрүүлэлт:

- Экспортыг дэмжих төсөл: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэж батлаагүйгээс "Махны салбарыг дэмжих экспортод чиглэсэн мал эмнэлгийн хорио цээрийн даглэм бүхий тусгай тусгаарлагдсан бүс байгуулахад тоног төхөөрөмж нийлүүлэх" 13.7 тэрбум төгрөгийн ажил хийгдээгүй;
- Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл: Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил гүйцэтгэх 4.8 тэрбум төгрөгийн ажил хугацаандаа дуусаагүй, хугацаа сунгаснаас материалын үнэ 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, 75 хувийн гүйцэтгэлтэй;
- Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл: Төсөл хэрэгжих нийт хугацаанд 65.7 тэрбум төгрөг зарцуулснаас УБДС ТӨХК тооцоо нийлсэн актаар 32.4 тэрбум төгрөгийг баталгаажуулсан боловч зардлын 33.3 тэрбум төгрөгийн зөрүүг урьдчилж гарсан зардалд тайлагнаагүй;
- Инженер, технологийн дээд боловсрол төсөл: Төсөл хэрэгжих хугацаанд оюутны сургалтын тэтгэлэгт олгосон 14.0 тэрбум төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2: Төслийн хэрэгжих хугацаа дууссан Ховд сум чиглэлийн авто зам барих ажлын гүйцэтгэл 36.9 хувь, Эрдэнэбүрэн сум чиглэлийн авто зам барих ажлын гүйцэтгэл 68.9 хувьтай, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүйгээр 2.8 тэрбум төгрөгийн шууд худалдан авалт хийсэн;
- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр: Тайлант онд 23.4 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 169.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, гэрээний хугацаа дууссан цэцэрлэгийн барилга угсралтын ажил 17.2 хувийн гүйцэтгэлтэй, 0.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан боловч барилгын ажил огт хийгдээгүй;

Аудитын санал дүгнэлт

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

Аудитын илрүүлэлт

Бүсэд асуудал

Дүгнэлт, зөвлөмж

- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж: Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд 6.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.
- Гадаад зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 10 төсөл хөтөлбөрийн бусад эргэлтийн хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй нийт 534.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 22 тусгай сангаас 20 тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлант онд 2 тусгай сан үйл ажиллагаа эхлээгүй тул аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан 20 тусгай сангаас 11 тусгай сангийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 9 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Боловсролын зээлийн сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих санд "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 5.8 тэрбум төгрөгийн 19 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 256.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 181.4 тэрбум төгрөгийн зөрчилд 43 албан шаардлага, 22.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 5 санал хүргүүлж, 51.6 тэрбум төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгч, 0.7 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Мөн холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 2.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс, 1.5 тэрбум төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 0.8 тэрбум төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өглөө.

Аудитын илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

- Анод банкны дамжуулан эзэлдүүлэх гэрээний 0.8 тэрбум төгрөг, Капитал банкны 3.9 тэрбум төгрөг, Овдлын нэгдсэн холбооны 13.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах асуудлыг шийдвэрлээгүй, харьяа 14 байгууллага 5.0 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 20.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Иргэдэд хүүгүй олгох 1.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Энт кредит ББСБ-тай байгуулсан гэрээний дагуу Финтек /Апкейшны зээл/ ашиглан цахим хэлбэрээр олгох үйлчилгээний хүүгийн зардалд 0.04 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан;
- Сангийн санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрээс 2014-2022 онд төв, орон нутагт 3 жилийн хугацаатай, хүүгүй олгосон зээлийн эргэн төлөлтөөс 6538 зээлдэгчтэй холбоотой, 15.5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй.

Боловсролын зээлийн сан:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 486 суралцагчийн 20.0 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 100 оюутны 5.5 тэрбум төгрөг, Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчид олгох тэтгэлэг авсан 149 суралцагчийн 3.4 тэрбум төгрөгийн тэтгэлгийн гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Өндөр хөгжилтэй оронд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцсан нийт 462 суралцагчийн 43.1 тэрбум төгрөгийн зээлийн, 159 суралцагчийн 10.0 тэрбум төгрөгийн хүүгийн авлагын, дэлхийн шилдэг их сургуульд суралцсан 164 харилцагчийн 66.8 тэрбум төгрөгийн зээлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй нийт 11.7 тэрбум санхүүжилт авсан 147 зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй, зээлийн эргэн төлөлтийн график байгуулаагүй.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан 14.4 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх эх үүсвэрийг төвлөрүүлээгүй;
- Сангаас олгосон шууд зээлийн 58.0 хувь буюу 99.4 тэрбум төгрөгийн 347 зээлдэгчээс авах авлага "муу зээл"-ийн ангилалд бүртгэлтэй, 53 зээлдэгчийн 5.4 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, баталгаажуулаагүй;
- Идэвхтэй зээлдэгчийн үлдэгдлийг FISCUS тооцооллын программд хаасан боловч санхүүгийн динамик программд үлдэгдэлтэй, хаагдаагүй 134 зээлдэгчийн нийт 0.1 тэрбум төгрөгийн зөрүүтэй байна.

Бусад сан:

- Ирээдүй өв сангийн хөрөнгөөс Монголбанк дахь Ирээдүйн өв сангийн дансанд 2023.12.28-ны өдөр 617.5 тэрбум төгрөг, 200.0 сая ам.доллар буюу 682.5 тэрбум төгрөг, нийт 1,300.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг гэрээ байгуулахгүйгээр байршуулсан;
- Спортыг дэмжих сан болон Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангуудын төсөв батлагдаагүйгээс үйл ажиллагаа явуулаагүй байна.

4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ. Үүнд:

- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийг зарим төсвийн ерөнхийлөн захирагч төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээр Төв төрийн сантай хоорондын тооцоо үүсгээгүйгээс Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын үлдэгдлийг 1,119.0 тэрбум төгрөгөөр илүү илэрхийлсэн, цэвэрлэх бичилт дутуу хийсэн /Тухайлбал: ХХААХҮС 435.6 тэрбум төгрөг, ЗТХС 333.7 тэрбум төгрөг, ЭХС 235.7 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 114.0 тэрбум төгрөг/;
- Монголбанканд байрших гадаад валютын дансны хаалтын ханшийг зөрүүтэй тооцсоноор мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 7.4 тэрбум төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Хуралдай бондын ханшийн залруулга 4.4 тэрбум төгрөгийг тайлагнаагүй байна.

4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 1, Сангийн сайдад 3, Барилга, хот байгуулалтын сайдад 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 72.2 хувийн биелэлттэй байна.

- Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад өгсөн 1 зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Сангийн сайдад өгсөн 2 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Барилга, хот байгуулалтын сайдад өгсөн 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын секторын дотоод аудитын бүтэц, орон тоог 2023 оны байдлаар авч үзэхэд нийт 62 төсвийн ерөнхийлөн захирагчдаас 54 нь дотоод аудитын нэгжтэй бөгөөд 546 албан хаагчидтай, үүнээс 314 дотоод аудитор ажиллаж байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, дотоод аудит, санхүүгийн шалгалт хийх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, чанарын баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд төсөвт болон төрийн өмчийн оролцоотой нийт 13 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийхээр батлагдсанаас төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 14, нийт 26 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны болон сэдэвчилсэн хяналт шалгалт хийсэн байна.

Аудитын санал
дүгнэлт

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Аудитын
илрүүлэлт

Бусад асуудал

Дүгнэлт,
зөвлөмж

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Тайлант онд “Сенчири II”, “Сенчири III” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалан эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасган “Гэрэгэ” үнэт цаасны төлбөрт 1,481.9 тэрбум төгрөг, “Хуралдай” үнэт цаасны төлбөрт 1,484.7 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлэх замаар өрийн зохицуулалт хийж, төлж төлбөрийн үүргийг хойшлуулсан байна.
2. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн Засгийн газрын баталгаатай гаргасан 30.0 тэрбум иений “Самурай” үнэт цаасны төлбөрт 720.0 тэрбум төгрөг, “Евро” үнэт цаасны төлбөрт 1,548.0 тэрбум төгрөгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.
3. Засгийн газрын үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй, тогтмол арилждаггүйгээс жишиг хүү болон өгөөжийн муруй зах зээлд тогтохгүй байгаа нь Засгийн газрын бонд, бусад засгийн газрын баталгаатай гаргаж буй үнэт цаасны өгөөж, эрсдэл бодитой тодорхойлогдохгүй байна.
4. Тайлант онд нийт төрийн өмчит хуулийн этгээдийн 62 буюу 45.2 хувь нь 508.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 239 буюу 55.8 хувь нь 81.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
5. Эрдэнэс Тавантолгой ХК-аас бусад Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө өмнөх оноос 9.0 хувь, өр төлбөр 9.6 хувиар өссөн бол ашиг 5.4 хувиар буурсан, Тавантолгой ХК-аас бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө өмнөх оноос 11.8 хувь, өр төлбөр 22.1 хувиар өссөн бол ашиг 26.2 хувиар буурснаас үзэхэд хөрөнгө, өр төлбөрийн өсөлт нь ашигт ажиллагаанд нөлөө үзүүлээгүй байна.
6. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хийсэн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй 5,588.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд нийт 11.0 тэрбум төгрөгийн амлалтын хүүгийн төлбөр төлсөн нь гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг авч, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгаагаас шалтгаалсан байна.
7. Засгийн газрын тусгай сангууд татварын орлогоос 743.7 тэрбум төгрөг, татварын бус орлогоос 757.6 тэрбум төгрөг, улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 2,468.0 тэрбум төгрөг, төсөв болон дамжуулан зээлээс эргэж төлөгдөх 46.8 тэрбум төгрөг, нэмэлт санхүүжилтээр 13.3 тэрбум төгрөг, нийт 4,029.4 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.
8. Төсвийн захирагчдын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 147 байгууллагын 394 газар эзэмших, ашиглах гэрчилгээгүй, 186 байгууллагын 368 газар кадастрын зургаар баталгаажаагүй эрх зүйн маргаан үүсгэх эрсдэлтэй, санхүүгийн бүртгэл дэх газрын хэмжээ, үнэлгээ цахим бүртгэлээс зөрүүтэй байна.
9. Төв төрийн сангийн 4,800.8 тэрбум төгрөгийн зарлагын эх үүсвэрийн дутагдлыг бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлэн санхүүгийн тайланд богино хугацаат зээлийн өглөгөөр тайлагнаж, Засгийн газрын нэгтгэсэн тайланд 36 байгууллага, сан, ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж цэвэрлэх бичилт хийсэн байна.

5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлаагүй хөрөнгө оруулалтын болон нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг төрийн өмчит хуулийн этгээдүүд нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлж байгаа нь байгууллагын ашигт ажиллагаа, төвлөрүүлэх ногдол ашигт нөлөөлж байгаа асуудлыг анхаарч хуулийн тодорхой зохицуулалттай болох;
2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт орсон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар дэмжлэг үзүүлэх;
3. Монгол Улсын Их хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор 25 төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахыг Засгийн газарт үүрэг болгосон боловч хэрэгжилтийг хангуулахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудын зээлээр санхүүжих болон эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх төсөл, арга хэмжээг Өрийн удирдлагын хуульд заасан шаардлага хангасан тооцоо, судалгаагаар нотлогдсон эсэхийг гэрээ байгуулахаас өмнө буюу хэлэлцээрийн түвшинд тодорхой болгох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Санхүү, төсвийн асуудал, Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулсан аргачлал, журмыг бий болгох;
2. Засгийн газрын тусгай сангуудын анх байгуулсан зорилго биелээгүй, үйл ажиллагаа доголдсон, хуульд заасан орлогын эх үүсвэрийг бүрдүүлээгүй, үр ашиггүй болох нь тогтоогдсон эсэхэд хяналт хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж, татан буулгах үндэслэл бүрдсэн эсэхийг тогтоож, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах;
3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангах талаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;
4. Төрийн аудитын байгууллагаас аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлага тооцох, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д

1. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах, өгөөжийн муруйг бий болгох зорилгоор үнэт цаасыг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд иргэн, хуулийн этгээдэд нээлттэй арилжаалан санхүүгийн зах зээлийн жишиг хүү буюу бенчмаркыг тогтоож, үнэт цаасны өгөөж, эрсдэлийг зах зээлийн зарчмын дагуу тодорхойлох;
2. Олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зээлийн шугамаас илүү таатай нөхцөлтэй байж болох бусад эх үүсвэр /төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгийн зах зээл зэрэг/-ээс санхүүжилт татах боломжийг судалж, бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

САНГИЙН САЙД-д:

1. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэл, үр дүнг олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын байгууллагуудтай хамтран хяналт хийж, зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, төслийн үр дүнг тооцож, ажлын гүйцэтгэлтэй төрийн аудитын байгууллага уялдуулан санхүүжилтийг олгож байх;

Аудитын санал
дүгнэлт

Аудит хийсэн
санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Үндсэн мэдээлэл

Санхүүгийн
тайлангийн
тодруулга,
аудитын дүн

Онцлох, гол,
бусад асуудал

Аудитын
илгэрлэлт

Дүгнэлт,
зөвлөмж

01

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

36

2. Төрийн өмчийн 50-аас доош хувийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэх асуудлыг шийдвэрлэж, төрийн нийтийн хөрөнгийн дүнг бүрэн илэрхийлэх боломжийг бүрдүүлэх;
3. Монголбанк болон Сангийн яамны зөвшөөрөлгүй нээсэн төсөвт байгууллагуудын арилжааны банк дахь дансыг хянаж, цаашид ашиглах эсэх талаар шийдвэр гаргах;
4. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдлээр тусгагдсан мөнгөн хөрөнгөөс эх үүсвэр бүрдүүлэхгүй байх.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг)-т даалгасугай.


3.Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д үүрэг болгосугай.


Д.ЗАГДЖАВ

Z:\Tushaal\2024\146\A_Tushaal\0607_SNAG_1.Docx






ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Харилцагч байгууллага	Гаргасан шийдэл	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/	Өгсөн албан тушаалтан
1	Сангийн яам Эрчим хүчний яам	Албан шаардлага хүргүүлэх	Гадаад зээлээр санхүүжүүлсэн 2018-2022 онд хэрэгжиж дууссан "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл"-ийн нийт 176,673,742,000.00 төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, авлагаар бүртгээгүй байна.	176,673.7	Ахлах аудитор П.Амарсанаа, Аудитор Ж.Нямцэцэг
2	Сангийн яам	Албан шаардлага хүргүүлэх	Зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд, графикийн дагуу эргэн төлөх боломжтой эсэх талаар эрсдэлийн үнэлгээг гадаад зээлийн санхүүжилтийг авахаас өмнө бодитоор тооцож, судалгаа хийж үнэлж, сонгох эрх зүйн орчин бүрдээгүйгээс нийгмийн шинжтэй, хөрөнгө оруулалтаар хэрэгжих боломжтой, эргэн төлөгдөх боломжгүй төсөл хөтөлбөрийг дамжуулан зээлээр санхүүжүүлснээс төсвийн 26 ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэрэгжүүлж байгаа төслүүдийн 2,820,991,117,546.74 төгрөгийн зээлийн гэрээний авлагын үлдэгдэлд ногдох хугацаа хэтэрсэн 751,905,950,061.50 төгрөгийн авлага бүртгэлтэй. Үүнээс: 2023 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж баталгаажуулсан 2,286,041,929,575.19 төгрөгт ногдох хугацаа хэтэрсэн 387,349,005,228.33 төгрөг, тооцоог нийлэх боломжгүй 534,949,187,971.55 төгрөгт ногдох хугацаа хэтэрсэн 364,556,944,833.18 төгрөгийн авлага бүртгэлтэй байна.	751,906.0	Ахлах аудитор П.Амарсанаа, Аудитор Ж.Нямцэцэг

3	Барилга, хот байгуулалтын яам	Албан шаардлага хүргүүлэх	Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний дагуу 2012 онд Бэрэн групп ХХК-д 173,633,909,216.11 төгрөг, Цагаан хуаран консалтинг ХХК-д олгосон 65,599,186,908.52 төгрөг, нийт 239,233,096,124.63 төгрөгийн дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлт хийгдээгүй, маргаан үүссэн асуудлыг гэрээний дагуу арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.	239,233.1	Ахлах аудитор П.Амарсанаа, Аудитор Ж.Нямцэцэг
4	Сангийн яам	Албан шаардлага хүргүүлэх	Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн гэрээний хугацаа дууссан нийт 10 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүжилтээр өмнөх онуудад бий болсон бусад эргэлтийн хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй нийт 534,110,972,040.33 төгрөгийн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлж, төслийн хаалтыг хийгээгүй байна.	534,111.0	Аудитор Ж.Мөнхтуул, Аудитор Г.Оюунтөгөлдөр
Нийт дүн				1,701,923.8	



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.

